



“Анхан болон давж заалдах шатны шүүхийн  
Тамгын газрын үйл ажиллагааг үнэлэх журам”-ын  
2 дугаар хавсралт

**ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН  
ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ**

**НЭГ. УДИРТГАЛ**

1.1. Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого, Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тухайн жил хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн тэргүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

**ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ**

2.1. Шүүхийн бие даасан байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

Дүн шинжилгээ

2.2. Шүүхийг хүний нөөцөөр хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

Дүн шинжилгээ

2.3. Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

Дүн шинжилгээ

2.4. Шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

Дүн шинжилгээ

2.5. Мэдээллээр хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

Дүн шинжилгээ

**ГУРАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ,  
АЖИЛ САЙЖРУУЛАХ САНАЛ**

**ДӨРӨВ. ХАВСРАЛТ**

4.1. Тамгын газрын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

4.2. Тухайн жилийн үйл ажиллагааны тайланд шүүгч, ажилтны өгсөн үнэлгээ /хурлын тэмдэглэл/ шүүгч нарын зөвлөгөөний тогтоол



## НЭГ. УДИРТГАЛ

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн Тамгын газар нь 2025 онд Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс Монгол Улсын шүүхийн хэмжээнд дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд шүүхийн үйлчилгээ болон хэргийн хөдөлгөөний удирдлагын чанарыг сайжруулах, шүүхэд иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах, шүүхийн захиргаа болон хэргийн хөдөлгөөний удирдлагыг оновчтой зохион байгуулах ажиллагааг амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа. Ингэснээр шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг ханган ажиллах нөхцөлийг бүрдүүлэв.

Тус шүүх нь Завхан аймгийн баруун хойд талд байрлах 9 сумыг харьяалан үйл ажиллагаа явуулж байна.



Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын “Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшүүлэх” зорилтын хүрээнд тус шүүхийн хараат бус байдлыг хангах, шүүхийн үйлчилгээг хариуцлагатай, ил тод зохион байгуулах, иргэд олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг өргөжүүлэхэд онцгой анхааран ажиллалаа.



зуухны галч, Үйлчлэгч нийт 24 шүүгч, шүүхийн захиргааны ажилтны бүрэлдэхүүнтэйгээр шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж ажилласан байна.



2025 онд Ерөнхий шүүгч, 2 шүүгч, Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, Мэдээлэл технологийн мэргэжилтэн, 3 шүүгчийн туслах, 2 шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, Ахлах нягтлан бодогч, Нярав, Эвлэрүүлэн зуучлагч, Эвлэрүүлэн зуучлагчийн туслах, Бичиг хэргийн эрхлэгч, Архивч, Бичиг хүргэгч, Жолооч, 3 уурын



## ХОЁР. ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ



### 2.1. Тамгын газар хэргийн хөдөлгөөний удирлагын чиглэлээр:

2.1.1. Нийт шүүгчийн чуулганы 2021.10.11-ний өдрийн 05 дугаартай тогтоолоор баталсан “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам”, тус шүүхийн 2024.12.25-ны өдрийн 141/ЗТ2025/00001, 2025.02.20-ны өдрийн 141/ЗТ2025/00012, 2025.09.16-ны өдрийн 141/ЗТ2025/00049 дугаартай шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу тайлант хугацаанд шүүхэд ирүүлсэн “Хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хэргийн хөдөлгөөний нэгдсэн системд хэрэг хуваарилах журмын дагуу бүртгэх, шилжүүлэх” ажлыг зохион байгуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аргачлал журмын хэрэгжилтийг ханган ажилласан.






2.1.2. Тус шүүхийн шүүгч нарын 2025 оны хагас, бүтэн жилийн байдлаарх шийдвэрлэсэн хэргийн болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанарыг судалгаа гаргаж Ерөнхий шүүгчид танилцуулан Шүүхийн ерөнхий зөвлөлд 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр 2025.06.19-ний өдрийн 141/ЗТ2024/00026 дугаартай шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын хамт цахимаар хүргүүлсэн байна.



2.1.3. Тус шүүхийн шүүн таслах ажиллагааны 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1, 2, 3-р улирлын тоон мэдээлэл болон шүүхийн тамгын газраас авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний талаар сар бүрийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын зөвлөгөөнд танилцуулж, шүүгчдийн зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд зохион байгуулсан шүүгч, ажилтнуудын 4 удаагийн зөвлөгөөнд танилцуулга мэдээлэл хийж ажилласан байна.




2.1.4. Хэргийн хөдөлгөөний удирдлагын E-CASE системд 1-11 хүртэлх сарын мэдээ 2025 оны 1, 2, 3 улирлын мэдээг оруулж ажилласан. Тус шүүхийн шүүн таслах ажиллагааны 2024 оны бүтэн жил, 2025 оны 1, 2, 3 улирлын тайлан мэдээ, Шүүхийн шийдвэрийн цахим сангийн мэдээг гарган Шүүхийн ерөнхий зөвлөлд цаасаар болон цахимаар хуулийн хугацаанд нь хүргүүлж ажилласан.

2.1.5 Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт болон шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг тогтоосон журмын дагуу хуваарилсан, томилсон эсэхэд хяналт тавьж, сар, улирал, хагас, бүтэн жилээр тоон мэдээллийг гаргаж, шүүхийн цахим хуудаст тогтмол байршуулан ажиллалаа.






2.1.6 Иргэний хэргийн **154**, Эрүү, зөрчлийн хэргийн **620**, Цагдан хорих **18**, Хянан магадлангийн **5** нийт **797** шүүх хуралдааны бэлтгэлийг хангаж, шүүх хуралдааны тов, тоймыг тухай бүр <https://live.shuukh.mn/> -д байршуулж, өөрийн шүүхийн цахим хуудаст холбосон байна.



2.1.7 Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 82 дугаар тогтоолоор батлагдсан “Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам”-ын дагуу 2025 онд хэргийн оролцогчдыг



зайнаас шүүх хуралдаанд оролцох нөхцөлөөр хангах зорилгоор “Zoom” программыг ашиглан иргэний 32, зөрчлийн 10, эрүүгийн 54, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний 2 буюу нийт 98 хэргийн оролцогчдоос баталгааг гаргуулж, цахимаар шүүх хуралдаанд оролцуулах ажлыг зохион байгууллаа. Шүүгчийн туслах шүүх хуралдааныг цахимаар явуулах техникийн нөхцөл, боломжийг судлан, зохион байгуулалтын арга хэмжээг авч, хэргийн оролцогчдын хуульд заасан эрхийг бүрэн ханган ажилласан байна.

2.1.8. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 94 дүгээр тогтоолоор батлагдсан “Шүүхийн шийдвэрийг цахим хуудсанд байршуулах журам”-д заасны дагуу [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) цахим хуудсанд шийдвэрүүдийг холбогдох журмын дагуу, тогтоосон хуулийн хугацаанд нь нийтэлж ажиллалаа.

Эрүүгийн хэргийн шүүх		Иргэний хэргийн шүүх		Захирааны хэргийн шүүх	
Анхан шатны тогтоол	134064	Анхан шатны шийдвэр	271050	Анхан шатны шийдвэр	20922
Давж заалдах шатны магадлал	26529	Давж заалдах шатны магадлал	36707	Давж заалдах шатны магадлал	9849
Хяналтын шатны тогтоол	4749	Хяналтын шатны тогтоол	13243	Хяналтын шатны тогтоол	4124
Зөрчлийн хэрэг		Зөрчлийн хэрэг		Зөрчлийн хэрэг	



Тайлант хугацаанд:

- **Эрүүгийн хэрэг** – нээлттэй **84**, хаалттай **2**, нийт **86** шийтгэх тогтоол
- **Иргэний хэрэг** – нээлттэй **241**, хаалттай **23**, нийт **264** шийдвэрийг тус тус цахим хуудсанд байршуулсан байна.



2.1.9. Тайлант хугацаанд шүүхийн шийдвэр, шүүхийн мэдэгдэх хуудас, эрүүгийн гүйцэтгэх хуудас, иргэний гүйцэтгэх хуудас, эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл, зэрэг шүүгчээс гарсан **3128** эрх зүйн актыг хэргийн оролцогчдын тоогоор байгууллага, иргэдэд хуулийн хугацаанд нь хүргүүлэн ажилласан байна.

2.1.10. Шүүн таслах ажлын төрлөөр холбогдох мэдээллийг бүртгэл, хяналтын нэгдсэн системд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрээр цаг тухайд нь оруулж, бүртгэл хөтлөн, мэдээллийн сан бүрдүүлэн хэргийн хөдөлгөөний нэгдсэн системээс шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд холбогдох мэдээллийг харах, мэдээ тайлан гаргах, ашиглах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн системд алдаа гаргасан тохиолдолд тухай бүр хүсэлтийг хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэст хүргүүлэн ажилласан байна.



**ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ, ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭД ХҮРГҮҮЛСЭН ХЭРГИЙН ТОО**

ХЭРГИЙН ТӨРӨЛ	ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХЭД	ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭД	НИЙТ
ИРГЭНИЙ ХЭРЭГ	3	2	5
ЭРҮҮГИЙН ХЭРЭГ	15	4	19
ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ	9		9
НИЙТ	27	6	33

2.1.11. Хавтаст хэрэг илгээх, хүлээн авах журмын хэрэгжилтийг хангаж, нийт **33** хэргийг шүүх хооронд илгээх, шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавин ажиллалаа.



## 2.2 Тамгын газар шүүхийн иргэдийн төлөөлөгчийн чиглэлээр:

2.2.1. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 03/1701 дугаар албан бичгээр иргэдийн төлөөлөгчийн нэрс ирүүлсний дагуу сонгогдсон иргэдийн төлөөлөгчийн нэрсийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг нягталж, тус шүүхийн Тамгын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/22 дугаар тушаалаар 2026-2027 онд шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг баталж, Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэн ажилласан байна.



2.2.2. Монгол Улсын шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсэгт заасны дагуу шүүх хуралдааны тов гармагц иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтаас шүүх хуралдаан бүрд 10 хүний нэрсийн дэд жагсаалтыг цахимаар эрэмбэлэн тохиолдолын журмаар сонгон тамгын газрын даргын тушаалаар батлуулан ажиллаж байна. Шүүх хуралдаан товыг ажлын 5 доошгүй өдрийн өмнө мэдэгдэх хуудас болон утсаар иргэдийн төлөөлөгч нарт мэдэгдсэн. 2025 онд иргэний хэрэгт 1, эрүүгийн хэрэгт 3 нийт 4 иргэдийн төлөөлөгч сонгогдож шүүх хуралдаанд оролцсон байна. Иргэдийн төлөөлөгчийн эрх, үүрэг, хүлээх хариуцлага, шүүх хуралдааны дэгийн талаар мэдээлэл өгөх ажлыг шүүгчийн туслахууд хариуцан хэрэгжүүлж, холбогдох баримтыг хэрэгт хавсарган ажиллаж байна.



2.2.3. 2025.04.18-ны өдөр Завхан аймгийн Тосонцэнгэл сумд, 2025.04.30-ны өдөр Их-Уул сумд, 2025.05.02-ны өдөр Тэлмэн сумын иргэдэд “Иргэдийн төлөөлөгчөөр оролцохын ач холбогдол”-ын талаар таниулах ажлыг иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэдэд болон тойргийн сумдад зохион байгуулсан нээлттэй өдөрлөгийн үеэр иргэдэд сургалт зохион байгуулж гарын авлага тарааж ажилласан байна.



-2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 03/1062 дугаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн албан бичгээр “Шүүхийн иргэдийн төлөөлөгч таны оролцоо” сэдэвт хэлэлцүүлэгт Тосонцэнгэл суманд оршин суугаа 6 иргэдийн төлөөлөгчийг танхимаар, 5 иргэдийн төлөөлөгчийг цахимаар хэлэлцүүлэгт оролцуулах ажлыг зохион байгуулсан байна.




-Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцохын ач холбогдлын талаар <https://court.tosontsengel.za.gov.mn> өөрийн шүүхийн цахим хуудаст байршуулсан байна.




### 2.3 Тамгын газар эвлэрүүлэн зуучлалын чиглэлээр:

2.3.1. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Ерөнхий зөвлөл болон Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2025 онд нийт 126 өргөдөл, нэхэмжлэл хүлээн авч эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсан байна.



-Тус шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд хүлээн авсан өргөдөл, нэхэмжлэлийг шийдвэрлэсэн байдлыг 2024 онтой харьцуулсан байдал:



2.3.2. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2025 онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс олгосон иж бүрэн тавилгаар хангасан. Мөн шүүхийн тамгын газраас эвлэрүүлэн зуучлагчийн туслахад зориулан хэвлэгч машин буюу шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж асуудлыг зохион байгуулалтын арга хэмжээгээр шийдвэрлэн хэрэгжүүллээ.



2.3.3. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр нөлөөг сайжруулах ажлын хүрээнд Ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны хүрээнд Хаан банк, 1-р цэцэрлэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс, сумдын шинээр томилогдсон багийн дарга нарт зэрэг 12 байгууллагуудад Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль болон давуу тал, онцлог сэдвээр сургалт зохион байгуулж, ажилтнуудтай харилцан ярилцлага, яриа таниулга хийж ажилласан байна.



-Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах ажлын хүрээнд “Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд хэрхэн өргөдөл гаргах вэ?”, “Эвлэрүүлэн зуучлал гэж юу вэ?” зэрэг танилцуулга, мэдээллийг бэлтгэн олон нийтэд хүргэж, мөн 2025 онд хүлээн авсан өргөдлийн тоо болон шийдвэрлэсэн байдлын талаарх мэдээг сар бүр байгууллагын албан ёсны вэб сайт болон цахим хуудсаар дамжуулан тогтмол байршуулж, олон нийтэд мэдээллээр ханган ажиллалаа.

**Шүүх дэх Эвлэрүүлэн зуучлалд хэрхэн өргөдөл гаргах вэ?**

Эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны талууд

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн эрхийн маргаан, гэр бүлийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэдэг. Маргааны оролцогчид нь өргөдөл гаргагч, уригдагч тал гэсэн нэршилтэй.

**Өргөдөл гаргах харъяалал**

Өргөдөл гаргагч нь уригдагч талын оршин суугаа газрын шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд өргөдөл маягтын дагуу бөглөж гаргана.

Эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны тов мэдэгдэх

Эвлэрүүлэн зуучлагчийн туслах эвлэрүүлэн зуучлалд гаргасан өргөдлийн дагуу уригдагч талтай угсаар ярьж, уулзалт болох хугацааг тохирч өргөдөл гаргагчийг товлосон хугацаанд ирэхийг угсаар мэдэгдэнэ.

**Эвлэрлийн гэрээ байгуулах**

Эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа нь талуудын хооронд гарсан маргааны талаар ярилцаж, талуудын хүсэл зоригийн илэрхийллийн дагуу хуульд нийцүүлэн, өөр хэн нэгэн этгээдийн эрх ашиг сонирхлыг хөндөхгүй бол эвлэрлийн гэрээ байгуулна.

**Шүүгчийн захирамж**

Талуудын байгуулсан эвлэрлийн гэрээг шүүгч хянаж үзээд шүүгчийн захирамж гаргадаг. Шүүгчийн захирамжаар эвлэрлийн гэрээ баталгаажуулах нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил хүчин төгөлдөр болсон гэсэн үг.

**Шийдэл**

Талуудын уулзалт зохион байгуулж богино хугацаанд зардал бага, нэг удаагийн уулзалтаар талуудын сэтгэлд нийцжүйц шийдэлд хүрдэг ба асуудлыг эв зүйгээр шийддэг.

**ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛ ГЭЖ ЮУ ВЭ?**

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАГЧ

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ДАВУУ ТАЛ

**Эвлэрүүлэн зуучлалын мэдээний тойм**

2024 ОН	2025 ОН
Нийт хүлээн авсан-35	Нийт хүлээн авсан-25
Татгалзсан, буцаасан-1	Татгалзсан, буцаасан-4
Шийдвэрлэсэн-31	Шийдвэрлэсэн-13
Амжилттай-28	Амжилттай-11
Амжилтгүй-3	Амжилтгүй-4
Үлдэгдэл-3	Үлдэгдэл-6


Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх дэх эвлэрүүлэн зуучлал

**ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ БАГ**



-Мөн Эвлэрүүлэн зуучлалын QR кодтой нэрийн хуудас хийлгэж өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж, иргэдийг мэдээллээр ханган ажиллаж байна.

**ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХ ДЭХ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛ**



- 📍 Завхан аймаг, Тосонцэнгэл сум, Дархан-Уул баг
- ☎ 70468086, 99722000
- 📄 Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх дэх Эвлэрүүлэн зуучлал

**RECONCILIATION SERVICE AT THE INTERSUM COURT IN TOSONTSENDEL SOUM, ZAVKHAAN AIMAK**




- 📍 Darkhan-Uul bag, Tosontsegeel soum, Zavkhan aimak
- ☎ 70468086, 99722000
- 📄 Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх дэх Эвлэрүүлэн зуучлал

-Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг олон нийтэд сурталчилж, таниулсны үр дүнд иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн “Шүүхэд баярлалаа” талархлын илэрхийллийг байгууллагын албан ёсны вэб сайт болон цахим хаягуудад байршуулан олон нийтэд хүргэж ажилласан.

**ШҮҮХЭД БАЯРЛАЛАА**

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх дэх Эвлэрүүлэн зуучлалд тус аймгийн Нөмрөг сумын Засаг даргын гаргасан иргэний эрх зүйн зургаан маргааныг хурдан, шуурхай шийдвэрлэж өгсөн Эвлэрүүлэн зуучлагч болон Зуучлагчийн туслахнарт баярлалаа.



Завхан аймгийн Нөмрөг сумын Засаг даргын тамгын газрын хүнс жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн Ц.Өлзийжаргал 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

**ТАЛАРХАЛ**

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх дэх Эвлэрүүлэн зуучлагчид Миний банк “Хаан банк”-ыг тогтоолон тус шүүхийн эвлэрүүлэн зуучлалтай тогтмол хамтран ажилладаг. Аливаа хэрэг маргааныг хурдан шуурхай хоёр талын эрхийг хамгаалан шийдвэрлэж өгөдөг талархаж байгаагаа илэрхийлж байна.



Хаан банкны Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь тооцооны төвийн менежер: Ж.Пүрэвхүү

2.3.4. Эвлэрлийн гэрээний төслийг ирсэн өргөдлийн дагуу Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 26 дугаар зүйлд зааснаар боловсруулан ажиллаж байна. Гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулахаас татгалзсан тохиолдолд түүний үндэслэлийг харгалзаж дахин талуудыг дуудан ажиллагааг явуулдаг бөгөөд тайлант хугацаанд 87 эвлэрлийн гэрээ байгуулж, шүүхэд шилжүүлж шүүгчийн захирамжаар баталгаажуулсныг 174 байгууллага иргэнд гардуулан ажилласан байна.

**ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ ГАРДУУЛСАН БАЙДАЛ**

- 87 ЭВЛЭРЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛЖ, ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛСЭН
- 174 ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАРДУУЛСАН










2.4.2 ШЕЗөвлөлөөс 2025 онд ирүүлсэн Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс өгсөн 15 Антивирусны программыг суулгаж ажилласан байна. Үүнд: 3 шүүгч, тамгын газрын дарга, 3 туслах, 2 нарийн бичгийн дарга, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, мэдээлэл технологийн мэргэжилтэн, эвлэрүүлэн зуучлагч, 2 хурлын заал, нярав нийт 15 компьютерт суулгаж өгсөн бөгөөд бусад техник хэрэгслийн

хэвийн үйл ажиллагааг тогтмол хангаж, шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж, техник хангамжид гарсан эвдрэлийн засвар, үйлчилгээг тухай бүрд хийж гүйцэтгэсэн. Цахилгаан тасраад сервер унтраад асах үед цаг буруу явж эхэлдэг. Төхөөрөмжийн хэвийн ажиллагаанд тогтмол хяналт тавьж цаг зөв ажиллаж байгаа эсэх дээр цахилгаан тасарсан тохиолдол бүрд хяналт тавьж анхааран ажиллаж байна. Мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, Иргэн-2014 R210 серверийг нэгдсэн дотоод сүлжээндээ ашиглаж түүнд хандсан хэрэглэгчдийн хэрэгцээтэй файл, өгөгдөл /дата/, баримт, мэдээллийн сан зэргийг 2025 оны 11 сарын 27-ны өдрийн байдлаар 1.24 TB файл хадгалж авсан байна.



2.4.3. Шүүх хуралдааны бичлэгийг 2013 оноос одоог хүртэл архивлаж байгаа бөгөөд тусгайлан бүртгэлийн дэвтэр хөтөлж шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нараар 7 хоног бүр гарын үсэг зуруулан баталгаажуулдаг бөгөөд хатуу дискэнд бичлэг архивлагдан шүүхийн серверийн өрөөнд хадгалагдаж байна. 2025 онд шинээр 1321 хурлын бичлэг хадгалсан. Үүнд: Иргэн 158, эрүү 363, зөрчил 758, цагдан хорих 40, хянан магадлан 2 бичлэг байна.




2.4.4 “Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх” албан ёсны вэб сайт болон “Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн Тамгын газар” фэйсбүүк цахим хуудсаар дамжуулан шүүхийн цахим хуудас, мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулж, мэдээллийн шуурхай, хүртээмжтэй байдалд анхааран ажиллалаа. Шүүхийн үйлчилгээний төрөл, шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулж, тухай бүр шинэчилж, шүүх хуралдааны



зар, тоймыг тогтмол нийтэлж ажиллав. Мөн шүүгчдийн зөвлөгөөнөөр баталсан хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журмыг цахим хуудаст байршуулан олон нийтэд мэдээлэв.

Түүнчлэн иргэдийн төлөөлөгчийн оролцоо, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нэгдсэн мэдээллийг улирал бүр цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах, нэхэмжлэлийн загвар, бүрдүүлбэр, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн холбогдох заалт, торгууль, хураамж төлөх банкны дансны дугаар зэрэг мэдээллийг тухай бүр шинэчлэн нийтэлж, тамгын газрын үйл ажиллагааны жилийн тайлан болон шүүхийн шийдвэрийг олон нийтэд тогтмол мэдээллэн ажиллаж байна.



2.4.5 2025 оны Шүүхийн тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тус шүүхийн гадаад сүлжээний топологи зураглалыг гаргуулсан байна.




-Мөн тус шүүхийн Тамгын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/20 дугаар тушаалаар “Шүүхийн үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх үүрэг бүхий баг” байгуулагдан ажиллав. Уг баг нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан

2025 оны 82, А/170 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Шүүхийн үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”, 3 дугаар хавсралтаар батлагдсан “Үнэлгээний хуудас”-ны дагуу эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Эрсдэлийн үнэлгээний дүнгээр “Мэдээллийн технологийн эрсдэл” 2.36 оноо буюу “их эрсдэлтэй” үнэлэгдсэн байна. Серверийн өрөө нь нарны шууд гэрэл тусахгүй, ус чийггүй, халуун хүйтний хэлбэлзэл багатай, тоос шороогүй, галын аюулгүй байдлын төхөөрөмж бүхий орчин байх шаардлагатай боловч одоогоор халуун хүйтний хэлбэлзэл ихтэй, галын дохиолол болон чийгшүүлэх төхөөрөмжгүй, галын аюулгүй байдал бүрэн хангагдаагүй зэрэг асуудал илэрч, зориулалтын тоног төхөөрөмж байрлуулах шаардлага тулгарч байна. Мөн шүүх хуралдааны танхимын бичлэг хийх камерын линзний бохирдол болон бичлэгийн чиглэл өөрчлөгдсөн эсэхийг шалгахад, 2013 оноос хойш ашиглагдаж буй бичлэгийн төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа дууссан, линзний эвдрэлтэй зэрэг техник ашиглалтын зөрчил илэрсэн тул шинэчлэх шаардлагатай гэж үзэж, холбогдох саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэн ажиллалаа.

2.4.6 Шүүх хуралдааны тэмдэглэлийг хөтлөхөд мэдээллийн технологийн дэвшилтэт программ хангамжийг ашиглах ажлын хүрээнд Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт “Chimege Protocol” сургалт орж, хэрхэн тэмдэглэлээ бичих талаар зааварчилгаа өгч ажиллалаа.




2.4.7. Шүүхийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, кибер халдлага, хортой код, спам, вирусээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр тухай бүр мэдээлэл өгч, шүүхийн имейл хаягт илэрсэн хортой код, спам, вирусыг тухай бүр арилгах арга хэмжээ авч ажиллаж байна. Тайлант хугацаанд тус шүүхийн имейл хаягт ирсэн 3 удаагийн хортой код, вирусээс урьдчилан сэргийлж нээхээс нь өмнө устгаж арилгах арга хэмжээ авч ажилласан байна. Шүүхэд мэдээллийн технологийг ашиглахтай холбогдсон хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг тогтмол зохион байгуулж 2025.01.13-ны өдөр “Кибер аюулгүй байдал” 2025.10.16-ны өдөр “Мэдээллийн аюулгүй байдал”, “Нууц үг үүсгэх, хадгалах” гэсэн сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгууллаа.






### 2.5 Тамгын газар архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

2.5.1. 2025 онд тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдол байхгүй болно.




2.5.2. Крилл хэвлэмэл хуудасны эх загварыг 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 1/10410 дугаартай албан бичгээр Шүүхийн тусгай архиваас батлуулж ирүүлсний дагуу Завхан аймгийн төрийн архиваар эх загварыг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр улсын байцаагчийн 19 дугаартай актаар батлуулан Завхан аймагт хэвлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг "Завхан принт" ХХК-иар хэвлүүлэн ажиллаж байна. Монгол бичгийн хэвлэмэл хуудасны эх загварыг Шүүхийн тусгай архивын улсын байцаагчийн 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 007 дугаартай актаар батлуулан Завхан аймагт хэвлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг "Завхан

принт" ХХК-иар хэвлүүлэн ажиллаж байна. Хэвлэмэл хуудсыг зохих журмын дагуу тусгай зориулалтын сейфд хадгалж, шаардах хуудас бичсэний дагуу хэвлэмэл хуудсыг олгон ажиллаж байна. 2025 онд Ерөнхий Шүүгчийн захирамж-1050ш, Шүүх хуралдааны тэмдэглэл-927 ш, Шийтгэвэр-3650ш, Шийдвэр-991, Шүүгчийн захирамж-3084ш, Шүүх А4 тоот-450ш, Тамгын газрын А5 тоот-590ш, Шүүх А5 тоот-680ш, Тамгын газрын даргын тушаал-260ш, Шийтгэх тогтоол-580ш, Гүйцэтгэх хуудас-450ш нийт 12712 ширхэг хэвлэмэл хуудсыг олгож ажилласан байна.



Мөн Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 2.2.5.1-д заасны дагуу, 2025 онд Шүүхийн цахим [tosontsengel\\_tg@shuukh.mn](mailto:tosontsengel_tg@shuukh.mn) хаягаар болон шуудангаар Шүүхийн ерөнхий зөвлөл болон иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичгийн дагуу хугацаа хоцрогдолгүй хэрэгжилтийг ханган ажиллалаа. **Үүнд:**




- Тайлан, хууль тогтоомж, дүрэм журамд санал авахтай холбоотой – 46 албан бичиг





зөрчлийн хэрэг, эрх зүйн акт баримтууд архивт орсон эсэхийг нягтлан шалгах”, 2025.02.25-ны өдөр Завхан аймгийн Прокурорын газарт шилжүүлэх 2024 оны эрүү, зөрчлийн хэрэг, эрх эрх зүйн актын өнгөн хувийн данс бүртгэл, Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Эрүүгийн хэргийн тусгай архивын баримт бичиг нягтлан шалгах комиссоор данс бүртгэл батлуулахаар, 2025.07.03-ны өдөр Батлагдсан данс бүртгэлийн дагуу хэрэг, өнгөн хувийг дахин нягтлах, 2025.10.16-ны өдөр тус шүүхийн архивт хадгалагдаж байгаа 2014-2019 оны 629 эвлэрлийн гэрээ, 2005 оны 175, 2018 оны 366, 2019 оны 245, 2020 оны 290 иргэний хэрэг устгах жагсаалтыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архивт хүргүүлэхээр тус тус хуралдсан байна.

2.5.5 Хадгаламжийн нэгж бүрдүүлэхдээ баримтын он цаг, нэр төрөл, асуудал сэдэв, байгууллагын үйл ажиллагааны чиглэл, байгууллага, иргэдтэй харилцсан байдал, зохиогчийн болон газар орны зэрэг үндсэн шинжийн аль нэгээр буюу хэд хэдэн шинжийг хослуулан ангилан төрөлжүүлж ", 5.3.1."байнга хадгалах, түр хадгалах баримтыг тус тусад нь ангилан төрөлжүүлэх" гэж заасны дагуу байнга хадгалах 654 хадгаламж нэгж түр хадгалах 4811 хадгаламж нэгжийг ангилан төрөлжүүлэн ажилласан байна.



Албан байгууллага болон иргэдээс ирүүлсэн нийт 114 албан бичиг, хүсэлтийн дагуу тус шүүхээс гарсан эрх зүйн актыг хуулбарлаж өгсөн байна. Архивын баримт ашиглалтын тоо бүртгэлийн тогтмол хөтөлж байгаа. 2025 оны 05 сарын 20-ны байдлаар 63-ИХ, 5-ЗХ, 12-ЭГ, 10-ЭЗ, Шийтгэх тогтоолын өнгөн хувь 2024, 2025, Эрүү иргэний бүртгэл 2023-2024, Тушаал 2024-2025

тус тус архивын баримтаас шүүгч , шүүгчийн захиргааны ажилтнуудад ашиглуулсан байна.

-Тус шүүхээр шийдвэрлэсэн эрх бүхий албан тушаалтны оногдуулсан шийдвэрийг шийдвэрлэсэн зөрчлийн 2021-2024 оны 1014 хадгаламж нэгж бүхий материалыг жагсаалтын дагуу 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Завхан



аймгийн Цагдаагийн газрын Тосонцэнгэл сум дундын цагдаагийн хэлтэст хүргүүлэн ажилласан байна.

-2025.09.15-ны өдөр 2017-2023 оны түр хадгалах эрүүгийн хэрэг 112, 2017-2023 оны зөрчлийн хэрэг 354, 2024 оны шийтгэх тогтоолын өнгөн хувь 4, 2024 оны зөрчлийн эрх зүйн актын баримтууд 27, нийт 497 хадгаламж нэгжийг Завхан аймгийн Прокурорын газарт шилжүүлж хүлээлгэн өгч ажилласан.



-Эрүүгийн хэргийн тусгай архивын дэргэдэх баримт нягтлан шалгах арга зүйн комиссын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн №02 дугаар хурлаар данс батлагдаж ирсэн данс бүртгэлийн дагуу 2024.09.22-09.23-ны өдөр Улсын ерөнхий прокурорын газрын Эрүүгийн тусгай архивд 2017-2023 оны байнга хадгалах 34 хадгаламжийн нэгж буюу 13 эрүүгийн хэргийг хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна.



2.5.6 Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 2.3.4-т "архивын баримтыг зориулалтын байр, тавиур, шүүгээнд холбогдох журам, стандартын дагуу хадгалах нөхцөл бүрдүүлэх" гэж заасны дагуу байрлуулсан. Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 6.14.4-т "тавиурын тавцан хоорондын зай нь хадгаламжийн нэгжийн өндрөөс 10 см-ээр илүү", 6.14.5-т "тавиурын доод тавцангаас шал хүртэлх зай 30 см-ээс доошгүй байх" гэж заасны дагуу тавиуруудыг байршуулаад байна. Тус шүүхэд архивын зориулалттай шүүгээ 2 ширхэг байгаа болно.



Архивын өрөөнд байвал зохих 9 тоног төхөөрөмжөөс автомат хийн гал унтраах төхөөрөмж, галын хор, гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, зориулалтын тавиур, шүүгээ, чийг, дулаан хэмжигч, аврах гарц, скайнер, компьютер зэргээр хангасан байна.

Архивын өрөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор хяналтын камер суурьлуулж, гэрэл сольсон байна.



Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 6.11.2-т архивын байр, өрөө тасалгаа, хадгаламжийн санд жилд 2-оос доошгүй удаа мэргэжлийн байгууллагаар хортон шавж, мэрэгчийн устгал, ариутгал, халдваргүйтгэл хийлгэх; гэж зааснаар 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдөр “Ариусгал Завхан” ХХК-аар ариутгал халдваргүйтгэл хийлгэж БАҮАНЖ-ыг баримтлан ажилласан байна.



Ариусгал Завхан ХХК –аас албан байгууллага аж ахуй нэгжид Ахуйн шавьж мэрэгч устгал, ариутгал халдваргүйтгэлийн үйлчилгээ хийсэн баримт

Албан байгууллагын нэр: Тосонцэнгэл сум шүүхийн тамгын газар

Нийт талбай: 36 м²

АШМУ Халдваргүйжүүлэлтийн стандарт MNS-5151-3: 2002 хангасан химийн бодис

- 1 Шавьж устгал 0,5% жилью, > 0,2% Аэрозоль фас гель, дихлорфос
- 2 Мэрэгч устгал Бромидиолон, Домовой прошка
- 3 Ариутгал халдваргүйтгэл - Кальци хлорид, (0,015%, 0,03%, 0,06%) жавелионы уусмал, хлорсет ДПЗТ, \_\_\_\_\_ зэрэг химийн бодисуудаар ариутгал устгал хийж гүйцэтгэв.

Төлбөр: \_\_\_\_\_ төгрөг

Ариусгал Завхан ХХК-ны захирал: \_\_\_\_\_ Албан байгууллагын нэр: Архив

Ариутгагч: Д. Давсани

Утас: 98218730 Утас: 96459348

2025 оны 10 сарын 13



2.5.7. 2024 онд нийт 8,695 хадгаламж нэгжийг цахимжуулсан. Тайлант хугацаанд шүүхээс гарч буй эрх зүйн актын болох 2024 оны гүйцэтгэх хуудас /2 файл/, 2024 оны эрүү, иргэн, зөрчил ерөнхий шүүгчийн захирамж /13 файл/, 2023, 2024 оны шүүгчдийн зөвлөгөөний тогтоол /2 файл/, 2023, 2024 оны тамгын газрын даргын тушаал /2файл/, Тамгын газрын явуулсан бичиг /2файл/, шийтгэвэр /34 файл/, шийтгэх тогтоол /7 файл/, 2024 оны эрүү, иргэн зөрчил шүүгчийн захирамж /29 файл/, шийдвэр /7 файл/, шүүхийн явуулсан бичиг /2 файл/, 2024 оны иргэний хэрэг /298 файл/, Иргэн-2025 он Шүүхийн шийдвэр 1-71 /3 файл/, Эрүү-2025 оны Шийтгэх тогтоол 1-62 /4файл/, Зөрчил-2025 оны Шийтгэвэр 1-294 /6 файл/, Шүүгчийн захирамж Иргэн-2025 оны 1-382 /6 файл/, Эрүү-2025 оны 1-117 /2 файл/, Шүүхийн явуулсан бичиг 1-240 /2 файл/-ийг эмхэтгэж цахимжуулж ажилласан байна.

Шийтгэх тогтоол 2024 он 28-53	2025.04.15 16:57	Microsoft Edge P...	175,100 KB
Шийтгэх тогтоол 2024 он 1-20	2025.04.11 10:05	Microsoft Edge P...	115,758 KB
Шийтгэх тогтоол 2024 он 1-27	2025.04.15 16:23	Microsoft Edge P...	172,514 KB
Шийтгэх тогтоол 2024 он 21-27	2025.04.11 10:11	Microsoft Edge P...	44,455 KB
Шийтгэх тогтоол 2024 он 28-57	2025.04.11 10:40	Microsoft Edge P...	174,476 KB
Шийтгэх тогтоол 2024 он 54-76	2025.04.15 17:25	Microsoft Edge P...	172,390 KB
Шийтгэх тогтоол 2024 он 77-91 (2)	2025.04.15 17:51	Microsoft Edge P...	81,241 KB
Шийтгэх тогтоол 2024 он 77-91	2025.04.11 11:47	Microsoft Edge P...	74,424 KB
Шийтгэх тогтоол 2024 он54-76	2025.04.11 11:14	Microsoft Edge P...	157,976 KB
Шийтгэх тогтоол 2025 он 1-14	2025.07.25 14:14	Microsoft Edge P...	28,259 KB
шийтгэх тогтоол 2025 он 15-31	2025.07.24 09:17	Microsoft Edge P...	29,439 KB
Шийтгэх тогтоол 2025 он 32-45	2025.07.24 15:59	Microsoft Edge P...	21,917 KB
Шийтгэх тогтоол 2025 он46-62	2025.07.24 16:21	Microsoft Edge P...	24,404 KB

2.5.8 Тус шүүхийн Тамгын газар нь байгууллагын архивын улсын нэгдсэн үзлэгийн бэлтгэл ажлыг ханган, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Байгууллагын архивын үйл ажиллагааны журам болон бусад холбогдох хууль, журмыг баримтлан архив зүйн ажиллагааг хийж, бэлтгэл ажлыг ханган ажилласан. Улмаар 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Завхан аймгийн Улсын үзлэгийн дэд комиссоос зохион байгуулсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам" болон "Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль" болон бусад хууль журамд нийцүүлэн Архив, албан хэрэг хөтлөлтийн урьдчилсан үзлэгт шалгуулан 97%-тай үнэлэгдсэн байна.


## **2.6 Тамгын газар шүүхийн бие даасан байдлыг хангах бусад чиглэлээр:**

2.6.1. Шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах үүднээс шүүхээр үйлчлүүлэх хэсгийг өөрсдийн дотоод нөөц боломжоор тохижуулан завсарласан. Ингэснээр шүүхэд мэдүүлэх эрхээ эдлэх иргэд тухайн орчинд тав тухтай, хүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн нөхцөлд үйлчлүүлэх боломжтой болсон.





2.6.2. Ерөнхий шүүгч, шүүгчийн өрөө, Эрүү, Иргэний хэргийн шүүх хуралдааны танхимыг эмульс будаг хийж, ажиллах нөхцөлийг тав тухтай болгон сайжруулж, шүүхийн байр, шүүх хуралдааны танхим, өрөөний цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгүүллээ.



Эрүү, Иргэний хэргийн шүүх хуралдааны танхимын тоног төхөөрөмжийн хэвийн нөхцөлийг тухай бүр ханган ажиллаж байна.

Шүүхийн байрны аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор бүх шүүгч, шүүхийн захиргаа болон үйлчилгээний ажилтнуудын өрөөг нэг бүрчлэн лацдуулах ажлыг зохион байгуулж, шинээр лац олгон хамгаалалтын нөхцөлийг бүрдүүлсэн байна.






2.6.3. Тус шүүхийн тамгын газар нь хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх шүүхийн үйлчилгээний үр нөлөө, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд сул хараатай болон харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан брайль үсгээр гарын авлага бэлтгэн гаргасан.



Шүүхийн байр руу нэвтрэх хашааны үндсэн хаалгыг шинэчилж, налуу зам бүхий гүйдэг хаалга болгон сольж суурилуулсан. Энэхүү шинэчлэл нь иргэд, үйлчлүүлэгчдийн шүүхийн байранд саадгүй, хялбар нэвтрэх боломжийг бүрдүүлсэн.

Иргэдэд үйлчлэх хэсэгт дэлгэцээс холбогдох мэдээллийг сонсох боломжтой чихэвч, нэхэмжлэлийн загварыг томруулж харах боломжтой харааны шил болон линз, сонсголын аппарат байршуулж, шүүхийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.






2.6.4. 2025 онд Эрүү, зөрчлийн хэргийн эд мөрийн баримтыг яллах дүгнэлтэд тусгагдсаны дагуу нэг бүрчлэн хүлээж авч, гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд 104 эрүүгийн хэргийн 88 ширхэг, 2 зөрчлийн хэргийн 2 ширхэг эд мөрийн баримтыг хүлээн авч хэрэгт дагалдан ирсэн тоног хэрэгсэл, төхөөрөмжийн хэвийн ажиллагаатай эсэхийг нэг бүрчлэн шалгаж, мэдээлэл лавлагааны хэсэгт байрлах камерын бичлэгээр баталгаажуулж хүлээн авсан байна.



2.6.5. Эд мөрийн баримт устгах орон тооны бус комисс нь 2025.03.20-ны өдрийн А/06 дугаартай тушаалаар шинэчлэгдэж, нийт 3 удаа хуралдаж комиссын гишүүдэд мэдээлэл сонсож, шаардлагатай арга хэмжээг авсан байна. Үүнд: давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хянагдаж ирсэн болон 2024 оны эрүүгийн 18 хэргийн 46 ширхэг, зөрчлийн 2 хэргийн 2 ширхэг эд зүйлийг устгах явцын гэрэл зураг, дуу, дүрсний бичлэгээр бэхжүүлж, бичгээр тэмдэглэл үйлдэж, акт 2 хувь үйлдэж хэрэгт 1 хувийг, байгууллагын хадгаламж нэгж болгон архивд 1 хувийг хүлээлгэн өгсөн болно.



2.6.6. Тус шүүхийн тамгын газрын даргын 2024.04.22-ны өдрийн А/12 дугаартай “Гамшгаас хамгаалах орон тооны бус анги байгуулах тухай” тушаалыг шинэчилж, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын төлөвлөгөөг Онцгой байдлын хэлтэстэй хамтран 2024.04.22-ны өдөр баталсан байна. Тайлант хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн тохиолдол гараагүй бөгөөд шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэн шүүхийн үйлчилгээг хүргэх, шүүхийн байранд аюулгүй байдлыг хангах, хамгаалах арга хэмжээг өдөр тутамдаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн тус шүүхийн байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг 2024.10.01-2026.10.01-ний өдрийг хүртэл 2 жилийн хугацаагаар, гал унтраах шуурхай төлөвлөгөөг гаргуулан ажилласан.



2.6.7. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хүргүүлсэн хууль тогтоомж, эрх зүйн актын төслийг тухай бүр шүүх, шүүхийн Тамгын газарт танилцуулан ажиллаж байна. 2024.12.23-ны өдрийн 02/01 дугаар албан бичгээр “Шүүхийн байрны стандарт”, “Шүүхийн үйлчилгээний стандартын хавсралт хэсэгт заагдсан Байгууллагын стандартын төсөл”, 2025.01.27-ны өдрийн 02/21 дугаар албан бичгээр 2025 онд ажиллах орон тооны санал,



“Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, шинэчилсэн найруулга”-д, Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны, Шүүхийн захиргааны ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих, хууль хэрэглэх, мэдлэг ур чадвар олгох, харилцаа хандлагыг төлөвшүүлэх шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг сайжруулахад чиглэсэн цахим сургалтын эрэлт хэрэгцээг тодруулах 2 санал, Эрүүгийн нэгдсэн аргачлалд 3 санал, Шүүхийн шийдвэрийн цахим хуудаст шийдвэр байршуулах журамд 2 санал, Шүүх хуралдаанд цахимаар оролцох журмын саналд 3, Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журамд 2 санал тус тус хүргүүлсэн байна.

### **ДҮН ШИНЖИЛГЭЭ**

2025 онд тус шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудтай хамтран олон талт ажил, арга хэмжээ зохион байгуулж, үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллалаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2025 онд дэвшүүлсэн зорилго, зорилтын дагуу “Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх” зорилгоор иргэд олон нийтэд чиглэсэн, шүүхээр үйлчлүүлж буй иргэд ил тод, нээлттэй, түргэн шуурхай үйлчилгээг хүргэж ажилласан. Үүнд:

1. Шүүхийн байр, үйлчилгээний орчин иргэдэд зориулсан тав тух, хүртээмж, хялбар нэвтрэх нөхцөл бүрдсэн.

2. Шүүхийн шийдвэрийг цахимд байршуулсан нь иргэдэд хүртээмжтэй, ил тод байдлыг сайжруулсан дүнтэй ажил болжээ. Иргэдэд зориулсан цахим мэдээллийн байршуулалт нь ил тод, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, иргэдийн оролцоог дэмжсэн үр дүнтэй ажил болсон.

3. Иргэдийн төлөөлөгчийн сонголт, нэрсийн баталгаажуулалт хуулийн шаардлагад нийцсэн, хууль ёсны журмын дагуу баталгаажсан байна. Иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаанд оролцуулах ажиллагаа тохиолдлын журмаар зохион байгуулагдсан, тов мэдэгдэл цаг тухайд нь хүргэгдэж, оролцооны баталгааг хангажээ. Сургалт, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулснаар иргэдийн төлөөлөгчдийн эрх, үүрэг, хариуцлага, шүүх хуралдааны дэгийн талаарх мэдлэгийг сайжруулж, оролцооны чанарыг дээшлүүлсэн.



4. Шүүх дэх Эвлэрүүлэн зуучлал нь олон нийтэд чиглэсэн сургалт, таниулах ажиллагаа, QR код ашигласан мэдээлэл нь иргэдийн оролцоо, мэдлэгийг нэмэгдүүлж, эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээг илүү хүртээмжтэй болгосон. Иргэдийн талархлын тоо, иргэний байгууллагаас ирүүлсэн санал нь эвлэрүүлэн зуучлалын нийгмийн хүлээн зөвшөөрлийг харуулж байна. Эвлэрлийн гэрээний баталгаажуулалт, хэрэгжилт нь хуулийн шаардлагад нийцсэн, хугацаанд нь зохион байгуулагдаж, шүүхийн үйл ажиллагааны чанарт эерэг нөлөө үзүүлж байна.

5. Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн тамгын газраас авч хэрэгжүүлсэн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ (өрөөнд тавилга, хэвлэгч машин) нь үйлчилгээний чанар, ажилтны бүтээмжийг сайжруулсан.

6. Хэвлэмэл баримт, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа журмын дагуу, эрэмбэлэгдсэн, хадгалагдсан. Цахимжуулалт сайн хийгдсэн нь шүүхийн мэдээллийн хүртээмж, хурд, архивын хяналтыг сайжруулсан. Архивын өрөө, хадгалалт, тоног төхөөрөмжийн бүрдүүлэлт, гал, чийг, аюулгүй байдлын хяналт стандартын дагуу хангагдсан. Улсын үзлэгийн үнэлгээ 97% гарч, шүүхийн архивын үйл ажиллагаа үнэлгээний өндөр үзүүлэлттэй гэж дүгнэж болно.

## 2.2. ШҮҮХИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙГ УДИРДАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2.2.1. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан орон тооны хязгаарт багтаан Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 43 дугаар тушаалын 34 дүгээр хавсралтад заасны дагуу тус шүүхийн тамгын газар нь 2025 онд нийт захиргааны 9, үйлчилгээний 13, нийт 22 шүүхийн захиргааны орон тооны хязгаар батлагдсан. Шинээр шүүгчийн туслах 1, бичиг хэргийн эрхлэгч 1, уурын зуухны галч 1 нийт 3 ажилтныг хууль тогтоомжид нийцүүлэн томилж, 2025 онд захиргааны 8, үйлчилгээний 13 нийт 21 шүүхийн захиргааны ажилтны бүрэлдэхүүнтэйгээр орон тооны хязгаарт нийцүүлэн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй ажилтан байхгүй бөгөөд туршилтаар хугацаагаар ажиллаж байгаа ажилтан 1 байгаа болно. Тус шүүхийн тамгын газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан орон тоонд багтаан хүний нөөцийг бүрдүүлэн ажиллалаа.

Шүүхийн ерөнхий захиргааны даргын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 43 дугаар тушаалын 34 дүгээр хавсралт

ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ДЭЭД ХВЗГААР

№	Албан тушаалын нэр	ШЕЗ-ийн 206-р тогтоол	Орон тооны хязгаар 2025 онд
1	Шүүхийн Тамгын газрын дарга	1	1
2	Мэдээлэл дамжуулах мэргэжилтэн	1	1
3	Шүүхийн туслах	4	4
4	Шүүх хуралдааны нэрийн бичгийн дарга	3	2
5	Бичиг хургалч	1	1
6	Хүний нөөц, дотоод ажил хариуцсан шатнаач	1	0
7	Олон нийттэй харилцах мэргэжилтэн	1	0
8	Мэдээллийн технологийн мэргэжилтэн	1	1
9	Мэдээллийн технологийн инженер	1	0
10	Эвлэрүүлэн зуучлагч	1	1
11	Эвлэрүүлэн зуучлагчын туслах ажилтан	1	1
12	Ахлах нягтлан бодогч	1	1
13	Архивч	1	1
14	Бичиг хэргийн эрхлэгч	1	1
15	Няраа	1	1
16	Эмч	1	0
17	Сэтгэл зүйч	1	0
18	Төрийн үйлчилгээний бусад гүйцэтгэх ажилтан (Жоохонч, мушгаан, слесарь, цахилгаанч, үйлчлэгч, гялч бусад)	6	6
Нийт		28	22

-000-



2.2.2. Шүүхийн захиргааны ажилтнуудын хувийн хэргийг "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-д заасны дагуу төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийн товъёог, төрийн албан хаагчийн анкет /Маягт 1/, танилцуулга



/Маягт 2/, албан тушаалын карт /Маягт 3/, боловсролын баримт бичиг, бүтээлийн жагсаалт, хувь хүний намтар, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэл үр дүнг үнэлсэн үнэлгээний хуудас, гүйцэтгэлийн тайлан, ажил байдлын тодорхойлолт, цээж зураг, бусад баримт бичиг зэргийг тус бүрийн хувийн хэргийг хөтлөх хавтаст бүрдлийг хангуулж, баяжилтыг

тухай бүр хийж гүйцэтгэж ажилласан. Нийт шүүхийн захиргааны 8, үйлчилгээний 13 ажилтны хувийн хэрэг байгаа болно.

2.2.3. Тус шүүхийн тамгын газрын дарга шүүхийн захиргааны ажилтнуудын албан тушаалын тодорхойлолт болон 2025 оны шүүхийн тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан Төрийн захиргааны 7 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Төрийн үйлчилгээний 13 албан хаагчийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хянан баталгаажуулж, биелэлтийн явцын ярилцлагыг 1, 3 дугаар улиралд, хагас бүтэн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг жилийн 2025.06.15-ны өдөр, 2025.12.20-ны өдрийн дотор үнэлж, үнэлгээг баталгаажуулж байна.

Засгийн газрын Хэргийн эрхийн газрын дарга 2025 оны 09 дугаар тушаалын 2 дугаар ивэсгэлт

**ЗАВХАН АЙМГИЙН ТОСОЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ШҮҮХ ХУРАЛДААНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Л.ЗОЛБООГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/А	Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ		Суурь түшиг	Хурал түшиг		Эцэст хүлээх	Дуусах хугацаа
	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шагтүү үзүүлэлт		Эцсийн хэлцэл	Суурийн хэлцэл		
1							
2							
Н.О.Г. "Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн үйл ажиллагааны тухай болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны Эрүү, Иргэн, Зөрчлийн шүүх хуралдааны бэлтгэл хажих, шүүх хуралдааны тэмдэглэлийг хуулийн хуралдаанд гаргах зэрэгчээг баталгаажуулах тухай үндэс зургуулах, Ерөнхий шүүгч, шүүгч нар, тамгын газраас гаргах шаардлагатай мэдээг тухай бүр гаргах, Ерөнхий шүүгч, тамгын газраас өндөр зурга, давжлалын гүйцэтгэл" ЗОРИЛТЫН ХУРААНД							
<i>(Албан тушаалын зорилго, зорилтой сууриг Г.ХХХ-ийн ажиллагааны зорилго)</i>							
1	Арга хэмжээ №1.1. Шүүх хуралдааны бэлтгэл зохион байгуулалтыг хангах.	Шүүх хуралдаан эхлэхээс өмнө хэргийн эрхэлдэгчдийн ноцгой ажил хуралдааны танилцыг багдан, дүү дүрс бэлтгэлийн төлөвөөр, төлөх хуралдааны хэргийн үйл ажиллагааг хангах.		50%	100%	2025.01 сар	2025.12 сар
2	Арга хэмжээ №1.2. Шүүх хуралдааны тэмдэглэлийг хуулийн хуралдаанд гаргах.	Эрүү, иргэн, зөрчлийн шүүх хуралдааны тэмдэглэлийг хуулийн хуралдаанд гаргах, шүүгчээр гарсан үсэг зургууль болуулан шүүхийн тусламд, хүргүүлэн өгч байх.		50%	100%	2025.01 сар	2025.12 сар

2.2.4. Шүүхийн тамгын газарт Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалгын албан бичгийг 2024.09.13-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хүний нөөцийн газарт хүргүүлэн, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газраас П.Ган-Эрдэнийг 2025.04.23-ны өдрөөс эхлэн шилжүүлэн томилон ажиллуулж байна. 2025.04.01-ний өдөр Л.Дэмидбалданг тус шүүхийн Уурын зуухны галчийн ажилд, 2025.04.01-ний өдөр О.Отгонжаргалыг Бичиг хэргийн эрхлэгчийн ажилд, 2025.07.21-ний өдөр Б.Даваажаргалыг Архивчийн ажилд тус тус томилсон байна. Мөн 2025.04.01-ний өдөр Б.Батбаярыг Шүүгчийн



81250700191



туслахын албан тушаалд, Б.Батхүүг Мэдээлэл лавлагааны мэргэжилтний албан тушаалд тус тус шилжүүлэн томилон ажиллуулж байна.



2.2.5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025.02.14-ний өдрийн 20 дугаар зарлигаар Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Завхан аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн шүүгч Пүрэвцэрэнгийн Доржбалыг Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилогдсон зарлиг гардуулах ёслолын ажиллагааг Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын газраас тус шүүхийн байранд 2025.02.21-ний өдөр зохион байгуулсан байна.

2.2.6. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах ажлын хүрээнд 2025.11.13-ны өдөр шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын дунд “3х3 сагсан бөмбөг”-ийн тэмцээн зохион байгуулсан байна. Мөн 7 хоногийн “Пүрэв гараг” бүрт тогтмол заланд тоглож байна.



2025.03.11-13-ны өдрүүдэд Завхан аймагт Зэвсэгт хүчний 104 жилийн ой, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан аймгийн үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулагдсан спортын тэмцээний “3х3 эмэгтэй сагсан бөмбөг”-ийн төрөлд 1-р байр, 2025.05.18-ны өдөр Нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан “Холимог гар бөмбөг”-ийн тэмцээн 3 дугаар байр, 2025.06.06-08-ны өдрүүдэд “Алтай таван богд 2025” баруун бүсийн шүүхүүдийн аварга шалгаруулах спортын 5 төрөлт тэмцээнд “Эрэгтэй теннис, Хосын теннисний төрөл”-д 1-р байр, “Шатар”-ын төрөлд 2-р байр, “Гар бөмбөг”-ийн төрөлд эрэгтэй, эмэгтэй баг тус бүр 3-р байр, “Сагсан бөмбөг”-ийн төрөлд эрэгтэй, эмэгтэй баг тус бүр 1-р байр, сагсан бөмбөгийн “Шилдэг эрэгтэй,



эмэгтэй тамирчин”-аар шалгарч, багийн дүнгээр 2-р байр эзэлж, тус тус амжилт гарган оролцсон байна.

Тус шүүх нь цаг агаарын эрс тэс уур амьсгалтай бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 1 давхарын хана мөөгөнцөртөж эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон учир чийгнээс хамгаалах хавтангаар сольж, шүүхийн иргэдэд үйлчлэх хэсгийн ханыг шинэчилсэн байна.



Тус шүүхийн уурын зуухны галч нарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинг сайжруулах зорилгоор 2025 оны 09 дүгээр сард галч нарын ажлын байрлах ахуйн байрыг тохижуулан засварласан байна.

Шүүгч, ажилтнуудын эрүүл ахуйн шаардлага хангасан орчинг бүрдүүлэх, иргэдийн тав тухтай үйлчлүүлэх нөхцөлийг хангах зорилгоор шүүхийн байрны уурын зуухны хуучин яндан ашиглалтын хугацаа дуусаж, цоорч эвдэрснийг шинэчилсэн байна.



Шүүхийн ерөнхий зөвлөлөөс олгосон 17 шүүхийн захиргааны ажилтнуудын өрөөний тавилга болох сандал, ширээ, тумбочка, сейф, мөн Ерөнхий шүүгч, Тамгын газрын дарга нарын өрөөний иж бүрэн тавилгыг угсарч байрлуулсан байна.



Шүүхийн ерөнхий зөвлөлөөс олгосон 6 иж бүрэн суурин компьютерийг Ерөнхий шүүгч, 2 Шүүгч, Шүүгчийн туслах, Мэдээлэл технологийн мэргэжилтэн, Ахлах нягтлан бодогч нарт хуваарилсан байна.

Шинээр 5 хэвлэгч машины худалдан авалт хийж 2

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, Зөвлөлдөх тасалгаа, Ахлах нягтлан бодогч, Эвлэрүүлэн зуучлагчийн туслах нарт хуваарилсан байна.



Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тус шүүхийн архивын баримтыг цахимжуулах ажлын хүрээнд цахимжуулалтыг эрчимжүүлэх зоригор Архивчид сүүлийн үеийн түргэн скайнер 2 ширхгийг олгосон байна.

Завхан аймгийн Тосонцэнгэл сумын “Мөнхийн алба” өрхийн эмнэлэгтэй хамтран шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр 2 удаа буюу 2025.01.17-ны өдөр эрдсийн, 2025.04.17-ны өдөр хавдрын маркерийн шинжилгээнүүдэд бүрэн хамруулсан байна.



2.2.7. 2024.01.23-ны өдрийн 02/17 дугаартай албан бичгээр шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудыг салбарын болон төрийн дээд одон медальд тодорхойлж материалыг хүргүүлсэн байна. Үүнээс: 2025.02.28-ны өдөр тус шүүхийн Шүүгч Б.Өлзийхишиг нь Төрийн




шагнал “ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-иар, 2025.03.20-ны өдөр Уурын зуухны галч Л.Цэрэннадмид, З.Отгондорж нар нь ШЕЗ-ийн “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ээр, 2025.07.02-ны өдөр Бичиг хүргэгч П.Нямсүрэн нь Төрийн дээд “АЛТАН ГАДАС” одонгоор, 2025.07.07-ны өдөр Мэдээлэл технологийн мэргэжилтэн Б.Баттулга нь ШЕЗ-ийн “ЖУУХ БИЧИГ”-ээр тус тус шагнагдсан байна.

Мөн Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн Уурын зуухны галч Л.Цэрэннадмидын Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл”-ийн ажилд оруулсан үнэтэй хувь нэмрийг үнэлэн, салбар зөвлөлөөс 2024 оны “ШИЛДЭГ ИРГЭН” шагналыг гардуулан өгсөн байна.

2.2.8. Тайлант хугацаанд шүүгч нар Завхан аймаг бүрэлдэхүүнд 3 шүүгч 5 удаа шүүгчийн туслах, шүүх харлдааны нарийн бичгийн дарга, жолоочийн хамт, 3 шүүгч 1 удаа Улаанбаатар хот руу “Нийт шүүгчдийн III-р чуулган”, Шүүгчийн сургалтад, 1 шүүгч 1 удаа тойргийн суманд очиж даалгавар гүйцэтгэх ажиллагаа явуулсан. Ахлах нягтлан бодогч 2 удаа Завхан аймагт аудит шалгуулах албан ажлаар, ахлах нягтлан бодогч, нярав 1 удаа ШЕЗ-д бараа материал худалдан авах албан ажлаар, Эвлэрүүлэн зуучлагч 1 удаа мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, жолооч гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг “Нээлттэй шүүх өдөрлөг” арга хэмжээг 2025.09.28-ны өдрөөс эхлэн 5 хоногийн хугацаатай тойргийн 5 сумд, бичиг хэргийн эрхлэгч, архивч, жолооч Завхан аймагт 1 удаа хэрэг шилжүүлэх ажлаар, ахлах нягтлан бодогч сургалтад Завхан аймагт 2 удаа ажилласан бөгөөд томилолтын зардлыг шүүхийн төсвөөс тухай бүр олгож ажилласан байна.

2.2.9. Монгол Улсын шүүхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шүүгчид 141/ЗТ2025/00009, 141/ЗТ2025/00019, 141/ЗТ2025/00023, 141/ЗТ2025/00021, 141/ЗТ2025/00056, дугаартай шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор 5 удаа чөлөө олгосон бол Шүүхийн захиргааны 15 ажилтанд 1-3 өдрийн





цалинтай чөлөөг Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем “ERP” болон чөлөөний хуудсаар, шүүхийн захиргааны ажилтанд тушаалаар 2 удаагийн цалинтай чөлөөг олгосон байна.

2.2.10. Тайлант хугацаанд тус шүүхийн шүүгч нар албан үүргээ гүйцэтгэх явцад бие махбодод гэмтэл, эрүүл мэндэд хохирол учирсан, нас барсан тохиолдолд гараагүй болно.




2.2.11. Шүүхийн захиргааны ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулах, идэвхжүүлэх хүрээнд тэдгээрээс гаргаж буй шинэ санал санаачлагыг дэмжин ажиллаж үр дүнд хүрсэн санал ажил, арга хэмжээ санаачлан зохион байгуулсан албан хаагчид нэмэлт оноо өгөх, ажлын үр дүн гүйцэтгэлд оруулан тооцож, үр дүнгийн урамшуулал болон ур чадварын нэмэгдэл олгох, шагналд нэр дэвшүүлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна. Тайлант хугацаанд шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг Төрийн дээд одон медаль, 3 ажилтныг салбарын шагналаар шагнаж урамшуулсан бөгөөд 2 ажилтны зэрэг дэв нэмэгдсэн байна. 2025 оны эхний хагас

жилийн ажлын үр дүнд үндэслэн 17 ажилтанд үр дүнгийн урамшуулал олгож, шүүхийн үйлчилгээний 13 ажилтанд ур чадварын нэмэгдлийг холбогдох дүрэм журмын дагуу 01-11 сар хүртэл олгосон байна. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг ахлах нягтлан бодогч, жолооч нарт, ажил хавсран гүйцэтгүүлсний нэмэгдэл хөлсийг 3 ажилтанд тус тус олгож ажиллалаа.

2.2.12. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд ажиллаж байгаа бөгөөд тус шүүхийн захиргааны ажилтнуудын хүйсийн харьцааг 12 эрэгтэй, 12 эмэгтэй шүүгч, ажилтантай бөгөөд хүйсийн харьцааг тэнцвэртэй байх нөхцөлийг хангаж ажилласан байна.




2.2.13. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг Засгийн газрын 2023 оны 98 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан журам, аргачлалын дагуу үнэлж дүгнэсэн бөгөөд 2025 онд тус шүүхийн тамгын газрын шүүхийн захиргааны 7, үйлчилгээний 13 албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг аргачлалын дагуу үнэлж, дүгнэж ажилласан. 2025 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг МУ-ын Засгийн газраас шинэчлэн баталсан журам, холбогдох аргачлалын дагуу 2025.12.20-ны өдрийн дотор үнэлж дүгнэхээр төлөвлөж байна.



2.2.14. Шүүхийн тамгын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/01 дугаар тушаалаар даргаар Н.Болдбаатар /нярав/, гишүүд Б.Баттулга /мэдээлэл технологийн мэргэжилтэн, Б.Алтансолонго /эвлэрүүлэн зуучлагч/ нарын бүрэлдэхүүнтэйгээр ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан бөгөөд шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, ёс зүй, сахилга хариуцлагыг бэхжүүлэх, ажлын цаг ашиглалтыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч байна. Тайлант хугацаанд тус шүүхийн захиргааны ажилтнуудтай холбоотой өргөдөл, гомдол ирээгүй байна. Тус шүүхийн захиргааны ажилтнууд нь 2025 онд ёс зүй, сахилга хариуцлага алдалгүй, ёс зүйн зөрчил гаргалгүй ажилласан байна.

Тус шүүхийн дэргэдэх “Ёс зүйн дэд хороо”-ноос 2025.01.17-ны өдөр “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”, 2025.01.23-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүй”, 2025.02.13-ны “Ажлын байран дахь харилцааны үр чадвараа сайжруулах 5 арга” сэдвээр сургалт зохион байгуулсан байна.

Тус шүүхийн шүүгч, захиргааны ажилтнууд нь 2024.12.20-ны өдрөөс 2025.09.01-ны өдөр хүртэл Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем “ERP” системээр ажлын цаг бүртгэлээ бүртгүүлэн ажилласан. 2025.09.01-ний өдрөөс эхлэн ШЕЗ-ийн “ERP” системээр ажлын цаг бүртгэлээ бүртгүүлэн ажиллаж байна.





2.2.15. Тус шүүхийн тамгын газарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад ажилтан Д.Даваажаргалыг “Шинэ жил”, “Цагаан сарын баяр”, “Ахмадын баяр”-ын өдрүүдээр хүлээн авч, жил бүр хүндэтгэл үзүүлж байна.



2.2.16 Шүүхийн захиргааны ажилтны холбооны татварыг сар бүр бүрэн төлж татварын өглөггүй ажиллаж байна. 2025 оны бүтэн жилийн татвар болох 480,000 төгрөгийг 2025.07.23-ны өдөр урьдчилж төлсөн байна.




2.2.17. 2025.01.23-ны өдөр Эвлэрүүлэн зуучлалаас Сингапур улсад Эвлэрүүлэн зуучлал хэрхэн хийгддэг талаарх үзүүлэн тоглолт сургалт, ШЕЗ-ийн “Арилжааны эвлэрүүлэн зуучлалын чиглэлд эвлэрүүлэн зуучлагчдын

чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт 16 цагийн багц мэргэшүүлэх сургалтад тус тус цахимаар амжилттай хамрагдсан байна. Мөн 2025.05.14-16-ны өдрүүдэд Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO)-аас Европын Холбооны санхүүжилттэй Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх нь” (2023-2025) төслийн хүрээнд Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дэргэдэх Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлтэй хамтран “Арилжааны эвлэрүүлэн зуучлалын чиглэлд эвлэрүүлэн зуучлагчдын чадавхыг бэхжүүлэх” сэдэвт сургалтад хамрагдаж гэрчилгээ гардан авсан байна.



“Шүүхийн захиргааны цахим сургалтын систем”-д байршсан Архив, бичиг хэргийн эрхлэгч нарт зориулсан сургалтын хүрээнд Баримт хадгалалт, хамгаалалт, Архивын баримтын хадгалалт, Архивын баримтын ажлын арга зүй, зохион байгуулалт, Эвлэрлийн гэрээ, Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, анхаарах асуудлууд, эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем, шүүхийн хэргийн хөдөлгөөний удирдлага, шүүхийн сэтгэл зүй, шүүгчийн харилцаа хандлага, Жендэрийн ойлголт, Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын системд нарийвчилсан журмын тохиргоо хийх тохируулах зааварчилгаа, Шүүн таслах ажиллагааны 2025 оны 1 дүгээр улирлын мэдээ тайлан гаргах заавар, Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем, шүүгчийн туслахууд зориулсан “Нотлох баримт хадгалалт, хамгаалалт”, “Хавтаст хэрэг хүлээн авах”, “Шүүгчийн ёс зүй”, “Захиргааны хэргийн шийдвэр боловсруулах аргачлал”, “Шүүгчийн туслахын үндсэн чиг үүрэг” сургалтуудад шүүхийн захиргааны болон үйлчилгээний ажилтнууд өөрсдийн чиг үүрэг бүхий хичээлүүдийг бүрэн судалсан байна.

2024.11.14-11.18-ны өдрүүдэд Завхан аймагт Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сургалтад мэдээлэл лавлагааны мэргэжилтэн Б.Батбаяр, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Батхүү, ахлах нягтлан бодогч Э.Доржналжирмаа нар хамрагдаж гэрчилгээ авсан байна. 2025.12.01-03-ны өдрүүдэд тус шүүхийн захиргааны 5 ажилтан Завхан аймгийн Худалдан авах ажиллагааны газарт АЗ сургалтад хамрагдахаар төлөвлөж байна.




Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн пүрэв гаригт цахимаар явуулж байгаа 7:4:10 сургалтад шүүхийн захиргааны ажилтнууд Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатарын “Ёс зүйн төлөв байдал, эрсдэлийн үнэлгээний арга зүйн асуудал” сургалт, Тагнуулын ерөнхий газрын Төрийн нууцын хэлтсийн ахлах, хошууч П.Амарбаясгалангийн "Төрийн нууцын хадгалалт, хамгаалалт" сэдэвт

сургалтуудад тухай бүр хамрагдсан байна.



Тус шүүхийн Нярав Н.Болдбаатар нь 2025.09.22 ны өдрөөс “Монголын хүний нөөцийн удирдлагын шинэчлэлийн академ”- ийн “ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан” бэлтгэх, хугацаатай лиценз олгох сургалтад хамрагдан 2025.11.06-ны өдөр төгсөж, “Сертификат” гардаж авсан байна.

2.2.18. Шүүхийн хүний нөөцийн програмд шинээр томилогдсон, шилжин ирсэн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудад бүртгэл нээсэн мэдээллийг журамд заасны дагуу ажлын 3 өдрийн дотор танилцуулан ажиллаж байна. Одоогоор нийт шүүхийн захиргааны 21 ажилтны мэдээллийг нягтлан шалгаж баталгааны хуудсанд гарын үсэг зуруулан ШЕЗ-д жил бүрийн 2025.06.01-ний өдөр хүргүүлсэн. Програм дахь шүүгч, ажилтны бүртгэл, мэдээлэлд баяжилт хийж тухай бүрд, баримт бичгийг хуулбарлан /PDF/ болгон оруулж байна.





## ДҮН ШИНЖИЛГЭЭ

2025 онд тус шүүхэд 1 шүүгч Завхан аймаг дахь сум дундын анхан шатны шүүхээс шилжин томилогдож ирсэн. Одоогийн байдлаар тус шүүх нь 3 шүүгч, 21 шүүхийн захиргааны ажилтаны бүрэлдэхүүнтэй ажиллалаа. Шүүхийн хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, мэргэшсэн шүүхийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, бодлого барьж ажилласны үр дүнд шүүхийн захиргааны 2 ажилтан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зарласан албан тушаалын тусгай шалгалтад тэнцэж төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөж шүүхийн шүүн таслах ажиллагааны нэг хэсэг болон ажилласан байна.

Мөн шүүхийн хүний нөөцийн программын ашиглалт, нөхөн бүрдүүлэлтэд тухай бүр хяналт тавьж шүүхийн захиргааны 21 ажилтны хувийн хэрэгт баяжуулалт хийж шинэчлэн, холбогдох мэдээллийг бүрэн гаргуулан авч хадгалалт, хамгаалалтыг шинэчлэн ажиллаж байна.

Тус шүүхийн болзол шаардлагыг хангасан шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудыг төрийн болон салбарын шагналаар шагнуулахаар баримт материалыг ШЕЗ-д хүргүүлснээс 2 ажилтан Төрийн дээд шагналаар, 3 ажилтан салбарын шагналаар шагнагдсан нь шүүхийн захиргааны ажилтнуудын итгэл зүтгэлийг үнэлэн, цаашид хийх бүтээх хүсэл эрмэлзлийг нэмэгдүүллээ.

Мөн тус шүүхийн тамгын газрын шүүхийн захиргааны ажилтнууд нь 2025 онд ёс зүй, сахилга хариуцлага алдалгүй, ёс зүйн зөрчил гаргахгүй ажилласан нь өмнө онтой харьцуулахад шүүхийн захиргааны ажилтнуудын ёс зүйн харилцаа хандлагад ахиц гарсан гэж үзэж байна.

### 2.3. ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ



Завхан аймгийн Цагдаагийн газрын Тосонцэнгэл сумын сум дундын цагдаагийн хэлтэс нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамгаалалтын цагдаа 1, харуулын цагдаа 3, нийт 4 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулсан. Одоогоор харуулын цагдаагийн 1 орон тоо дутуу ажиллаж байна.

2025 онд Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхээр нийт 2,979 иргэн үйлчлүүлсэн бөгөөд тэднийг зохих журмын дагуу шалгаж, шүүхийн байранд нэвтрүүлэн, уулзах албан тушаалтнуудад нь мэдэгдэж, дэг сахиулах болон аюулгүй байдлын хяналтыг тогтмол хэрэгжүүлж ажиллалаа.



2.3.1. Тус шүүхийн Тамгын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/20 дугаар тушаалаар “Шүүхийн үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх үүрэг бүхий баг” байгуулагдан ажилласан. Уг баг нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан 2025 оны 82, А/170 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Шүүхийн үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”, 3 дугаар хавсралтаар батлагдсан “Үнэлгээний хуудас”-ны дагуу эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэлээ. Үнэлгээний үр дүнд:

- “Харуул хамгаалалтын эрсдэл” 1.43 оноо буюу **бага** эрсдэлтэй,
- “Шүүх хуралдааны дэг сахиулах ажиллагааны эрсдэл” 1.54 оноо буюу **дунд** эрсдэлтэй гэж тус тус үнэлэгдсэн байна.

Үнэлгээний дүнгээс харахад:

- **Харуул хамгаалалтын эрсдэл 1.43** оноо буюу **бага эрсдэлтэй** гэж үнэлэгдсэн боловч дотоод аюулгүй байдлын зарим өндөр эрсдэлтэй хүчин зүйлс илэрсэн байна. Тухайлбал галын дохиолол ажиллахгүй байх, ослын гарц болон ослын шат дутуу байх зэрэг нь осол, галын аюул тохиолдсон үед хүний амь нас, эрүүл мэнд, байгууллагын өмч хөрөнгөд хор уршиг учруулах магадлалтай байна.
- **Шүүх хуралдааны дэг сахиулах ажиллагааны эрсдэл 1.54** оноо буюу **дунд эрсдэлтэй** үнэлэгдсэн нь шүүх хуралдааны хэв журмыг хангах хүний нөөц дутмаг, тусгаарлах өрөөнд аюулын дохиоллын төхөөрөмж байхгүй зэргээс шалтгаалан аюултай нөхцөл байдал үүсэх, хурцадмал байдал бий болох үед шуурхай арга хэмжээ авах боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.

Эрсдэлийн үнэлгээний үр дүн нь шүүхийн аюулгүй байдлын инженерийн дэд бүтцийг сайжруулах, хамгаалалтын хүний нөөцийн бодлогыг оновчтой болгох, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах шаардлагатайг харуулж байна. Хэрэв дээрх асуудлуудыг цаг алдалгүй шийдвэрлэхгүй бол шүүхийн үйл ажиллагаа доголдох, шүүх хуралдааны хэв журмын зөрчил, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл нэмэгдэх магадлалтай байна.

2.3.2 Тус шүүхээр эрүүгийн хэргийн 161, иргэний хэргийн 199, зөрчлийн хэргийн 583, цагдан хорих 18, хянан магадлан 5 нийт 987 шүүх хурал явагдаж, 1491 оролцогчдод шүүх хуралдааны дэгийг танилцуулж, “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам”-д заасны дагуу шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.



2.3.3. Тайлант хугацаанд шүүгчид хууль ёсны эрх ашгаа хамгаалах зорилгоор шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагад тайлбар, хүсэлт гаргах, нотлох баримт бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх шаардлага үүсээгүй. Мөн шүүгчийн эрх ашгийг зөрчсөн, хараат бус байдлыг алдагдуулсан талаар шүүгчээс гомдол, хүсэлт ирээгүй болно.

2.3.4 Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны гишүүн, аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчийн шүүн таслах үүргийн хэрэгжилтэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх тохиолдол гараагүй.

2.3.5 Шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг зөрчсөн, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах, шүүгчийн эрх ашгийг зөрчих нөхцөл байгаагүй тул ийм тохиолдлоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалах арга хэмжээг дангаар болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албатай хамтран хэрэгжүүлэх шаардлага гараагүй болно.

2.3.6. 2025 онд тус шүүхийн 3 шүүгчид хуулиар зөвшөөрсөн бие хамгаалах хэрэгсэл болох "Цахилгаан бороохой"-г шинээр олгосон бөгөөд хэвийн ажиллаж байгаа бөгөөд тухайн бие хамгаалах тусгай хэрэгслийн хадгалалт, хамгаалалтад тухай бүр хяналт тавьж, 2025.09.15-ны өдөр Завхан аймгийн Цагдаагийн газрын



Тосонцэнгэл сумын сум дундын цагдаагийн хэлтэстэй хамтран шүүгч нарт "Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх, хадгалах" сэдэвт сургалт зохион байгуулж, тусгай хэрэгслийг хэрхэн ашиглах, хамгаалах талаар зааварчилгаа өгөн ажилласан байна.

2.3.7. Тайлант хугацаанд шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл байдал үүсээгүй бөгөөд ямар нэгэн хамгаалалтын арга хэмжээ авч, шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах,







2.3.10. “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам”-д зааснаар шүүх хуралдааны танхим, шүүгчийн өрөөнд аюулын дохио өгөх тусгай төхөөрөмж суурилуулсан болно.




Шүүхийн иргэдэд үйлчлэх хэсэгт ачаа тээш түр хадгалах, цоож түлхүүр бүхий төмөр шүүгээ байрлуулсан.




Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг тусгаарлах өрөөнд хяналтын камер суурилуулсан. Мөн шүүхийн байранд хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн албан хаагч хяналт тавьж ажилладаг.




Тус шүүхийн тусгаарлах өрөө нь 10 м<sup>2</sup> хэмжээтэй, хамгаалалтын төмөр хаалттай бөгөөд байнгын камерийн хяналттай ажилладаг. Тусгаарлах өрөөнд саатуулагдсан иргэний аюулгүй байдлыг хангах үүднээс 2025 онд хана болон хамгаалалтын төмөр хаалтанд зөөлөвч суурилуулж, нэмэлт гэрэлтүүлэг хийж, өрөөг бүрэн засварласан.



Мөн тогтмол эрүүл ахуйн хэвийн нөхцөлийг хангах зорилгоор цэвэрлэгээ, ариутгалыг тогтмол хийн гүйцэтгэж байна. Тусгаарлах өрөөнд саатуулагдсан этгээдийн эрх, үүрэг болон хориглосон зүйлийн талаарх мэдээллийн самбарыг нүдэнд ил харагдах газар байрлуулсан.



Шүүхийн байрны нэгдүгээр давхарт Эрүүгийн болон Иргэний хэргийн шүүх хуралдааны танхимууд, мөн яллагдагч, шүүгдэгч, ялтныг түр хугацаагаар тусгаарлах өрөө байрладаг. Нэгдүгээр давхрын бүх цонх болон хоёрдугаар давхрын 202 тоот өрөөний цонх хамгаалалтын төмөр хаалттай. 2025 онд хоёрдугаар давхарын хонгилын 2 цонхонд нэмэлт хамгаалалтын төмөр хаалт шинээр хийж суурилуулсан.







Шүүх хуралдааны дэг сахиулагч цагдаагийн алба хаагч нарыг согтууруулах ундаа хэрэглэсэн байж болзошгүй этгээдийг согтуурлын зэрэг тогтоох зориулалтын багаж, төхөөрөмж /драгер/-өөр шалгах нөхцөлийг бүрдүүлсэн.

2.3.11. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 2020 онд баталсан бөгөөд 2024.04.22-ны өдөр А/12 дугаар тушаал шинэчлэн гаргаж, тодотгол хийсэн. Шүүхийн барилга байгууламж болон түүний гадна орчинд аюулт үзэгдэл, гамшиг үүссэн үед ажиллах талаар онцгой байдлын албатай баталсан төлөвлөгөөний дагуу танхимын болон дадлага сургуулилтыг 2024.05.20-ны өдөр хийж, бэлэн байдлыг хангасан. Мөн 2025.11.12-ны өдөр тус сумын Онцгой байдлын хэлтсээс "Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх", "Уурын зуухны аюулгүй ажиллагаа", "Цаасан баримтны галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх" сэдвээр сургалт хамтран зохион байгуулж ажиллалаа.



2.3.12. Тамгын газрын даргын 2024.04.22-ны өдрийн А/12 дугаар тушаалаар Онцгой нөхцөлд ажиллах ажилтнуудын нэрс, ажлын зааврыг баталж, харуулын цагдаа болон шүүгч, ажилтнуудад урьдчилан танилцуулж, гарын үсэг зуруулан баталгаажуулсан.



2.3.13. Шүүгчийн хараат бус байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, олон нийтэд хандсан соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд "Нөлөөллийн мэдүүлэг", "Шүүгчийн хараат бус байдал"-ын талаар гарын авлагыг шүүхийн цахим болон фэйж хуудас, шүүхийн үйлчилгээний хэсэгт, мэдээллийн самбарт тус тус байршуулан ажилласан.

2.3.14. Тайлант хугацаанд өөрийн амьдарч байгаа орон байранд галын аюулгүй байдал, гэмт халдлагаас хамгаалагдсан эсэхэд мэргэжлийн байгууллагаар үзлэг хийлгэж, дүгнэлт гаргуулах тухай шүүгч нараас хүсэлт ирүүлээгүй бөгөөд мэргэжлийн байгууллагад хандсан тохиолдол гараагүй болно.

## ДҮН ШИНЖИЛГЭЭ

Тайлант хугацаанд шүүгчийн хараат бус байдалд халдсан, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлсөн, нөлөөлөхийг оролдсон тохиолдол гараагүй, шүүгч нараас нөлөөллийн мэдүүлэг хөтөлж ирүүлээгүй бөгөөд шүүхийн тамгын газраас цагдаагийн байгууллагатай нягт хамтран ажиллаж байгаа нь үр дүнд хүрч байна гэж үзэж байна.

Гэвч харуулын цагдаагийн орон тоо дутуу, галын дохиолол, ослын гарц, тусгаарлах өрөөнд тоног төхөөрөмжийн дутагдал байгаа тул нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна.



Эрсдэлийг бууруулах, шүүхийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангахын тулд хамгаалалтын цагдаагийн хүний нөөцийг нэмэгдүүлэх, галын болон ослын аюулгүй байдлын системийг сайжруулах, тусгаарлах өрөө, шүүх хуралдааны танхимд техникийн хяналтыг бүрэн хангах шаардлагатай байна гэж дүгнэлээ.

Мөн шүүхийн шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг тусгаарлах өрөөнд саатуулагдсан иргэний аюулгүй байдлыг хангах үүднээс хана болон хамгаалалтын төмөр хаалтанд зөөлөвч суурилуулж, хяналтын камер байршуулан нэмэлт гэрэлтүүлэг хийж өрөөг бүрэн засварласан байна. Мөн аюулгүй байдлыг хангах үүднээс шүүхийн байрны нийт өрөөний хаалганы лацийг шинэчилж, өрөөнүүдийн нөөц түлхүүр хадгалах хайрцаг байршуулан ажиллалаа.


## 2.4. ШҮҮХИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2.4.1. Шүүхийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн төслийг тус шүүхийн сүүлийн 3 жилийн үйл ажиллагааны зардал, зах зээлийн үнийн өсөлт, бараа материалын үнэ ханш, бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн, үндэслэл, журмын дагуу боловсруулан 2026 оны төсвийн төсөл, 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус гарган Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх ажлыг зохион байгууллаа.

2.4.2. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 1,395,057,804 төгрөгийн санхүүжилт авсан байна. Үүнд:

- ✓ Цалин хөлс-886,152,266
- ✓ ХХОАТ-97,292,360
- ✓ Ажил олгогчоос НД төлөх шимтгэл-266,138,672.87
- ✓ Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал-32,291,163.78
- ✓ Хангамж бараа материалын зардалд-47,368,786
- ✓ Нормативт зардал-255,000
- ✓ Эд хогшил урсгал засвар-39,652,760
- ✓ Томилолт зочны зардал-12,433,300
- ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж-3,000,000 төгрөгийг тус тус улсын төсвөөс санхүүжилтээр авчээ.

2025 онд батлагдсан төсвийг зориулалт, эдийн засгийн ангиллын үр ашигтайгаар нийт санхүүжилтийн 91,6% зарцуулсан гүйцэтгэлтэй байна.




2.4.3. 2025 онд тус шүүх нь 4 шүүгч, 22 шүүхийн захиргааны ажилтны орон тоотой ажиллахаас 3 шүүгч, 21 шүүхийн захиргааны ажилтны бүрэлдэхүүнтэй ажиллалаа. Цалин хөлсийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоол, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 15-ны



өдрийн 72 дугаартай тушаалыг баримтлан тооцоолж байгаа ба батлагдсан цалингийн сан, орон тоонд багтаан цалин хөлсийг ТАЦНС-ээр цалинг тооцоолон олгож буй бөгөөд тайлант хугацаанд үндсэн цалинд 763,3 сая, ур чадварын нэмэгдэлд 240.9 сая, унаа хоолны хөнгөлөлтөд 67,4 сая, үр дүнгийн урамшуулалд 21,4 сая төгрөг нийт 678,1 сая төгрөгийн цалин, эрүүл мэндийн даатгалын санд 22.1 сая, нийгмийн даатгалын шимтгэлд 266,1 сая төгрөгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцон олгож санхүүгийн тайланд бүрэн тусгасан байна. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны цалингаас холбогдох татвар, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тооцож, өр, авлагагүй ажилласан байна.

2.4.4. Тус шүүхийн тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж, төсвийн ерөнхийлөн захирагчид чухал шаардлагатай мэдээ, тайлан, судалгааг тогтоосон хугацааны дотор гарган ажиллаж байна. Тайлант хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү хөрөнгө оруулалтын газарт 2026 оны төсвийн төсөл, шүүхийн захиргааны



ажилтнуудын цалингийн судалгаа болон захиргааны албан тушаалтнуудын цалингийн нэмэгдэл, тавилгын хугацаа сунгах болон актлах хөрөнгө, тогтмол зардалын судалгаа, төлөвлөгөөний хэрэгжилт ханган ажиллах тухай, 2020-2025 онуудад хууль бус шийдвэрийн улмаас төрийн албанаас халагдсан хүн байгаа эсэх, төрийн албаны зөвлөлөөс болон шүүхээс тогтоосны дагуу төсвөөс нөхөн олговор өгсөн эсэх талаарх судалгаануудыг гаргаж хүргүүлсэн байна. Архивын өрөөний хэмжээ болон шаардлагатай нягтаршуулсан шүүгээний тоо, шүүх хуралдааны танхимуудын план зураг, тавилгын судалгаа гаргаж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү хөрөнгө оруулалтын газарт 2025.03.19-ний өдөр хүргүүлсэн.

2.4.5. Нягтлан бодох бүртгэлийн дагуу анхан шатны баримт /төлбөрийн хүсэлт, нэхэмжлэл, зарлагын баримт, е-баримт/-ын бүрдлийг хангаж ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд байгууллагын галлагаанд 13,5 сая төгрөгийн галын мод, нүүрс, 19,8 сая төгрөгийн бензин шатахуун, 600,0 мянган төгрөгийн байгууллагын хог ачуулсан, 8,9 сая төгрөгийн аж ахуйн материал, 28,9 сая төгрөгийн урсгал засварын материал, 17,5 сая төгрөгийн бичиг хэргийн материал, 10,7 сая багаж, техник хэрэгсэл, 3,0 сая бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамж, 1,119 сая төгрөгийн мэдээлэл, технологийн үйлчилгээ, 11,2 сая төгрөгийн шуудан холбоо, интернэтийн зардал, 8,297 сая төгрөгийн гэрэл цахилгаан, 255,0 мянган төгрөг нормын хувцас зэрэг худалдан авах ажиллагааг хийж гүйцэтгэхэд анхан шатны баримтыг бүрдлийг бүрэн хангуулан ажилласан байна.

2025 онд бараа материалын шаардах хуудас, орлого, зарлагын баримт бүрдэл бүрэн, баримтын жагсаалтыг хавсаргаж, архивласан 2025 онд харилцагч байгууллагын үүсгэсэн нэхэмжлэхийн 98 ш баримтыг үндэслэн 98 ш орлогын баримт, шүүгч, шүүхийн захиргааны ажилтан, бусад 183 ш шаардах хуудсыг

үндэслэн 183 ш зарлагын баримт үйлдэж бараа материалын анхан шатны баримт бүрдүүлсэн. Анхан шатны баримтын дагуу программ хөтлөлтийг үйлдэж программ хөтлөлтөд тухай бүр хяналт тавьж ажиллаж байна.

2.4.6. 2025 онд тус шүүхийн тамгын газраас [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудсыг ашиглан худалдан авах ажиллагаа явуулаагүй.





2.4.7. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудаст 2024 оны бүтэн жилийн тайлан, 2025 оны 1, 2, 3-р улирлын тайлан болон сар бүрийн санхүүгийн тайланг үнэн зөв, иж бүрэн байршуулан ажиллаж байна. 2025

онд нийт 109 мэдээг хуулийн хугацаанд оруулсан байна. Хугацаа хэтэрсэн мэдээлэл байхгүй болно.

2.4.8. Тус шүүхийн тамгын газраас төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох дүрэм, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь улсын секторын нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн ажиллаж байна.


2.4.9. Шүүхийн эд хөрөнгийг хүчин төгөлдөр анхан шатны баримтад үндэслэн бүртгэж, нягтлан бодох бүртгэлийн программаас хэвлэсэн эд хариуцагчийн картын дагуу эд хөрөнгөтэй тулган тоолж баталгаажуулан, эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр 2 удаа хийсэн.







Тус шүүхийн тамгын газрын даргын 2025.06.18-ны өдрийн А/11 тоот “Эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг томилох тухай” тушаалаар Шүүгчийн туслах Б.Энхриймаа /Ажлын хэсгийн ахлагч/, ШХНБД Л.Золбоо, ШХНБД П.Ган-Эрдэнэ, Бичиг хүргэгч Нямсүрэн, Эвлэрүүлэн зуучлагчийн туслах М.Сүххуяг /Нарийн бичгийн дарга/ нарын бүрэлдхүүнтэй томилогдсон ажлын хэсэг 2025.06.23-ны өдрөөс 2025.06.27 – ны өдрийн хооронд байгууллагын үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллого хийсэн.

Тамгын газрын даргын 2025.11.18-ны өдрийн А/23 тоот “Эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг томилох тухай” тушаалаар Эвлэрүүлэн зуучлагч Б.Алтансолонго /Ажлын хэсгийн ахлагч/, ШХНБД П.Ган-Эрдэнэ, МЛМ Б.Батхүү, Бичиг хүргэгч Нямсүрэн, ШХНБД Л.Золбоо /Нарийн бичгийн дарга/ нарын бүрэлдхүүнтэй томилогдсон ажлын хэсэг 2025.11.24–ний өдрөөс 2025.11.28–ны өдрийн хооронд байгууллагын үндсэн хөрөнгө болон бараа материалын бүтэн жилийн тооллого хийсэн.



2.4.10. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, албан тасалгааг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх ажлын хүрээнд батлагдсан төсвөөс принтер 5 ширхгийг 3.999 мянган төгрөгөөр шинээр худалдан авсан байна. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Архивын ажилтны албан хэрэгцээнд хурдан хувилагч машин 2 ширхэг, Ерөнхий шүүгч, Тамгын газрын дарга, Шүүхийн захиргааны ажилтны 17 ширхэг иж бүрэн өрөөний тавилга олгосныг угсарч өрөө тус бүрт байрлуулсан байна.



2.4.11. Тус шүүхийн тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, тавилга эд хогшил дансанд бүртгэлтэй 48 нэр төрлийн нийт 34,721,783.5 төгрөгийн үнэ бүхий нийт 144 ш тавилга, эд хогшил, машин тоног төхөөрөмж дансанд бүртгэлтэй 30 нэр төрлийн нийт 83,404,857,00 төгрөгийн үнэ бүхий 56 ш техник тоног төхөөрөмжийг актлах, данснаас хасах саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн байна.



2.4.12. Тус шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, гарын авлага, бичиг хэрэгсэл /бичгийн цаас, принтерийн хор, үдээс/ зэрэг бусад шаардлагатай материалаар хангах ажлыг зохион байгуулж 2025 оны жилийн эцсийн байдлаар хангамж бараа материалын зардалд 17,5 сая төгрөгийн, ном хэвлэлд 168,0 мянган төгрөгийн зардал тус тус гаргасан байна.

2.4.13. Тус шүүх нь 2 автомашинтай. "Renault Duster" маркын 2021 онд орж ирсэн, 2021.07.27-ны өдрөөс тус шүүхэд ашиглагдаж эхэлсэн. 2025.11.14-ний өдрийн байдлаар моторын өвөл, зуны тосыг хугацаанд нь сольсон. Зүүн талын урд дугуйны цапны шариг, урд дугуйны тормосны наклад, дугуйны олгой хаймер зэргийг сольсон. 2025 онд нийт 995,000 төгрөгийн засвар, үйлчилгээ хийгдсэн. 2025.10.06-10.24-ний өдрийн хооронд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Нийт шүүгчийн 3 дугаар чуулган"-д оролцоод буцах замд эвдрэл гарч зогссон. Одоогоор өнгө үзэмж хэвийн, эвдэрсэн учраас үйлчилгээнд явахгүй байгаа.



"Тоёота Прадо-150" маркийн автомашин 2013 онд орж ирсэн, 2013 оноос тус шүүхийн үйлчилгээнд ашиглагдаж байна. 2025 онд моторын тосыг хугацаанд нь сольсон. 2025 онд Нийт 1,8 сая төгрөгийн засвар үйлчилгээг явах эд ангид хийсэн. Өнгө үзэмж дунд зэрэг, Рулийн дээд аппарат эвдэрсэн оноштой, жолооны хүрд хатуурсан, тухайн машины сэлбэгийг захиалсан байгаа болно. Тухайн тээврийн хэрэгсэлд гарсан гэмтлийг тухай бүр засварлан ашиглаж байна.

2.4.14. Тус шүүхийн 2 автомашиныг тээврийн хэрэгслийн хяналтын Улсын үзлэг, тооллогод тухай бүр бэлтгэн "Тоёота Прадо-150" автомашиныг 2025.05.10 ны өдөр, "Renault Duster" маркын автомашиныг 2025.05.12 ны өдөр үзлэг оношилгоонд хамруулсан бөгөөд автомашины ашиглалт, техникийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж байна.





Автомашины ашиглалтын картыг 2 автомашин тус бүрт нь нээсэн ба тухайн автомашинд хийсэн хуваарьт үйлчилгээ засвар хийсэн тэмдэглэлийг хөтлүүлж, тухай бүр хяналт тавин ажиллаж байна.

Гүний худгагт 150мм тэй хуванца хоолой суурлууж, худгаас гарах усыг цэвэршүүлэх Хайрган шүүр тавьсан. Ингэснээр худагт зэврэлт, хөлдөлт үүсхээс хамгаалах, гарч байгаа усыг цэвэршүүлэх, цэвэр усны носос хэвийн ажиллагаатай байх нөхцөл бий болсон – 2,4 сая төгрөг.



Шүүхийн байрны уурын зуухны хуучин яндан нь Шүүхийн байрны уурын зуухны хуучин яндан нь ашиглалтын хугацаа дууссан, зэврэлт үүссэн, утаа алдах зэрэг асуудалтай болсон тул аюулгүй ажиллагааг хангах, халаалтын тогтвортой байдлыг сайжруулах, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинг бүрдүүлэх зорилгоор

шинэчилсэн байна. 12 метр яндан – 960,000 төгрөг, Өргөгч каран 2 цаг 100,000 төгрөг, нийт 1,060,000 төгрөг болсон байна.

2025 оны 09 дүгээр сард уурын зуухны галч нарын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орчинг сайжруулах зорилгоор галч нарын ажлын байрлах ахуйн байрыг тохижуулан засварласан байна.





“Мөн Нутгийн үйлс” ХХК хэвлэх үйлдвэрт нөөц түлхүүрийн хайрцаг, шүүхийн байрны гадна хаяг хийлгэсэн байна.



2.4.15. Тус шүүхийн тамгын газрын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, худалдан авах ажиллагааны тайлан, эрүүл мэнд, нийгмийн даатгал болон хувь хүний орлогын албан татварын тайланг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагад тухай бүр хүргүүлэн ямар нэг алдаа зөрчилгүй ажиллаж байна.

The infographic features the following text:

- МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА
- АНХ АХУЙН НЭГТНИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР ХӨНГӨЛӨЛТ
- НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД
- ЭЛЭГДЭЛ ТООЛОХ ҮНДСЭН ХӨРӨНГӨ ОРЧУУЛАН ХӨРӨНГӨ ОРЧУУЛАЛТ
- ХАРИУЦАН КАМАГАГДСУН БУСАД ЭТГЭЭДЭД ОРЛОГСОН САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ
- ХАНДИВ
- ЭДГЭСЭР ЗАРЛЛЫГ НӨГӨЛЧУЛСАН АЛБАН ТАТВАРААС ХАСАЖ ХӨНГӨЛНӨ
- ТАТВАР НОГОДОХ ОРЛОГЫН 1%
- ХҮРТЭЛ ХЭМЖЭЭНИЙ ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ ҮЙЛЧИЛГЭН ЭХЭЛЛЭЭ
- ААНДАТ-ЫН ТЭХАЙ ХУУЛЬ 22.9 ДЭХ ХЭСЭГ
- Монголын Татварын алба | mta.gov.mn

The screenshot shows the website of the National Social Security Agency (Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар) with the following elements:

- Logo and name: "НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР"
- Navigation menu: "НҮҮР", "ТАНИЛЦУУГА", "ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ", "Е-ДААТГАЛ", "ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ", "СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ"
- Search and filters: "Бүх мэдээллээс", "Хайлт хийх түлхүүр үгээ оруул"
- Advertisement for Soginokhairhan Dureg: "СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ", "ТӨРИЙН САН 1002 0099 0000", "ТӨРИЙН БАНК 1037 0000 2249", "ХААН БАНК 501 926 1648"



Тус шүүхийн ахлах нягтлан бодогч нь 2025.01.16-ны өдрөөс 2025.01.23-ны өдрүүдэд Завхан аймгийн Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Санхүүгийн хяналт дотоод аудитын алба, Статистикийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар болон Санхүү, төрийн сангийн хэлтэстэй тооцоо нийлэх ажлыг зохион байгуулсан бөгөөд байгууллагуудтай өглөг, авлагын үлдэгдэлгүй гэж тооцоо нийлсэн байна.

Мөн Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж, **“Өөрчлөлтгүй дүгнэлт”** авсан нь санхүүгийн тайлан хөтлөлт, бүртгэл тооцоолол хууль, стандартын шаардлагад нийцэж байгааг харууллаа.


## ДҮН ШИНЖИЛГЭЭ

Тайлант хугацаанд шүүхийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох санхүүгийн хууль, журмын хүрээнд зохион байгуулж, төсвийг эдийн засгийн ангиллын дагуу үр дүнтэй, хэмнэлттэй зарцуулахад онцгойлон анхаарч ажилласан байна. Үүний үр дүнд шүүхийн үндсэн үйл ажиллагаа болох шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй үргэлжлүүлэх санхүүгийн баталгааг бүрдүүлж чадсан.

Шүүгч болон шүүхийн захиргааны ажилтнуудын цалин хөлс, томилолтын зардал, татвар, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тогтоосон хугацаанд бүрэн, үнэн зөв тооцон олгож, мөн байнгын хэрэглээний зардлууд болох халаалт дулаан, цахилгаан, автомашины бэлэн байдлын зардлыг төлөвлөгөөтэйгээр шийдвэрлэн байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллав. Үр дүнгийн болон ур чадварын нэмэгдлийг шударга, ил тод зарчмын хүрээнд үнэлэн олгосон нь ажилтнуудын хөдөлмөрийн урамшуулал, бүтээмжид эерэгээр нөлөөлжээ.

Шүүхийн ажиллах орчныг сайжруулах чиглэлд анхаарч, шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангах, урсгал засварын ажлуудыг цаг хугацаанд нь хийж, мөн иргэдэд үйлчлэх хэсгийн их засварын ажлыг шүүхийн захиргааны ажилтнуудын дотоод нөөц боломжоор гүйцэтгэсэн нь төсвийн хэмнэлт, үр ашигтай зарцуулалтын тод жишээ боллоо.

2025 оны 01 дүгээр сарын 16-23-ны өдрүүдэд Завхан аймгийн Татвар, Нийгмийн даатгал, Статистик, Санхүү төрийн сан, Санхүүгийн хяналт дотоод аудитын алба болон Орон нутгийн өмчийн газартай байгуулсан тооцоо нийлэлтийн дүнгээр өглөг, авлагын үлдэгдэлгүй баталгаажсан нь санхүүгийн бүртгэл, тайлагналын бодит, ил тод, хариуцлагатай байдалд өгсөн үнэлгээ юм. Мөн Төрийн аудитын газраас 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд **“Өөрчлөлтгүй**






**дүгнэлт”** авсан нь байгууллагын санхүүгийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо тогтвортой, үр дүнтэй байгааг нотлов.

Тайлант хугацаанд санхүү, төсвийн тайлан мэдээг үнэн зөв гарган холбогдох байгууллагад хуулийн хугацаанд нь хүргүүлж, шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод байршуулах ажлыг тогтмол хэрэгжүүлсэн нь нээлттэй, хариуцлагатай, ил тод санхүүгийн бодлогыг хэрэгжүүлж байгааг харуулж байна.

## 2.5. МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ



2.5.1. Тус шүүхийн цахим хуудсыг 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн хэвийн ажиллагааг тогтмол хангаж, 2024 оны шүүгчдийн зөвлөгөөний тогтоол, шүүхийн тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны шүүн ажиллагааны бүтэн жилийн мэдээ, эвлэрүүлэн зуучлалын 2024 оны бүтэн жилийн мэдээ, 2025 оны хагас жилийн мэдээний тойм, 2025 оны 01-03 дугаар улирлын шүүн таслах ажиллагааны эрүү, иргэн, зөрчлийн мэдээ, иргэдийн төлөөлөгчдийн оролцооны мэдээний тойм, 2025 оны 01 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэлх сар бүрийн мэдээний тойм, шүүхийн тамгын газраас 2025 онд хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл, шүүхийн шийдвэрийн тойм, цаг үеийн мэдээ мэдээлэл зэрэг нийт 205 мэдээ, мэдээллүүдийг цахим сайт болон фейж хуудаст оруулан иргэд олон нийтэд түгээн ажилласан байна. Тус шүүхийн фэйсбүүк фейж хуудас нь 2024 онд 1500 гишүүдтэй байсан бол 2025 онд 1900 болж өссөн байна.



Мөн тус шүүхийн гадна байрлах мэдээллийн самбарыг шинэчлэн байршуулан цаг үеийн мэдээ мэдээлэл болон шүүх хуралдааны товыг тогтмол байршуулан ажиллаж байна.






Тус шүүхийн тамгын газраас оюуны спортыг дэмжих, хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуулийн 1-2, 3-5 дугаар ангийн сурагчдыг хамруулан даамны



тэмцээн зохион байгуулсан байна.

2.5.2. Шүүхийн тамгын санхүүгийн нээлттэй ил тод байдлыг хангах иргэдийг мэдээллээр хангах зорилгоор Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)



цахим хуудаст 2024 оны бүтэн жилийн тайлан, 2025 оны 1, 2, 3-р улирлын тайлан болон сар бүрийн санхүүгийн тайланг үнэн зөв, иж бүрэн байршуулан ажиллаж байна. 2025 онд нийт 109 мэдээг хуулийн хугацаанд оруулж иргэдийг мэдээллээр хангаж ажилласан байна.

Мөн тус шүүхийн тамгын газарт сул орон тоо гарсан тохиолдолд ажлын байрны зарыг бэлтгэн сайт болон фэйж хуудсанд байршуулан хүний нөөцийн ил тод, нээлттэй байдлыг бүрдүүлэн ажиллаж байна.

**АЖЛЫН БАЙРНЫ ЗАР**  
Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын газарт "Жолооч"-ийн ажлын байранд урьж байна.

**БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Жолоочийн үнэмлэхийн хуулбар
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- Төрийн албан хаагчийн анкет
- 4 хуви цээж зураг (4\*6 хэмжээтэй)
- Боловсрол, мэргэжлийн диплом, гэрчилгээ /үнэмлэх, сертификат/ -ийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Цагдаагийн ерөнхий газрын ял шийтгэлтэй эзэх лавлагаа /төрийн үйлчилгээний цахим системээс авах/

**ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- Бурал дунд ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
- Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан байх
- Ажлын болон хувийн зохион байгуулалт сайтай, хариуцлагатай, Автомашин зөжих мэдлэгтэй, В, С, D ангилалтай байх
- Ачаалал даах чадвартай байх

**МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА:**  
2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн дотор тус шүүхийн [tosontsengel\\_tg@shuukh.mn](mailto:tosontsengel_tg@shuukh.mn) цахим хаягаар болон 204 тоотод хүлээн авна.

Холбоо барих утас: 99858526, 70468075

**ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР**

**Эвлэрүүлэн зуучлагчийн туслахын түр орон тоон дээр сонгон шалгаруулалт зарлаж байна**

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын газрын эвлэрүүлэн зуучлагчийн туслахын түр орон тоон дээр ажиглан шалгаруулж авна

**Тавигдах шаардлага:**

- Эрх зүйч мэргэжилтэй
- "Албан хаагч хөдөлмөр чадвартай" Коммунистийн хэрэгсэлийн программууд дээр ажиллах чадвартай
- "Хариуцлагатай, нягт нямбай, баяаг ажиллах болон ажлын ачаалал даах чадвартай, ирдэх санаачлагатай"

**Бүрдүүлэх материал:**

- Ажилд орох өргөдөл
- Төрийн албан хаагчийн анкет
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Боловсролын түвшинг тодорхойлох баримт бичиг
- Эрүүгийн харууцлага хүлээж байгаагүй тодорхойлолт /6-тогтоо/-аас

Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн иргэний материалыг 2024 оны 11 сарын 11 өдрийн 15.00 цаг хүртэл Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын газрын 204 тоот өрөөнд болон [tosontsengel\\_tg@shuukh.mn](mailto:tosontsengel_tg@shuukh.mn) хаягаар хүлээн авна.

Ажлын шалгаруулалтад тэмцэн ирсэгдэйд ярилцлага хийж, сонгон шалгарууна. Холбоо барих утас: 70468075

**Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын газарт "Архив"-ийн ажилтан шалгаруулж авна**

**ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- Бичигч болон гүүрсээ эзлэх боловсролын зэрэгтэй
- Бичигч бичих боловсролтай чадвартай
- Албан хаагч ажлын нэмэлтэй
- Компанийн хэрэгсэлийн програмууд дээр ажиллах чадвартай байх
- Монгол Бичигч хэрэгсэлийн чадвартай байх
- Архив, албан хаагч хөдөлмөр илэр ошуулах сууринд хамрагдсан байлал дүүрэг тал болно.

**БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**


- Ажилд орохыг хүссэн өргөдөл;
- Дипломын хуулбар;
- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар

**Материал хүлээн авах хугацаа**  
2025 оны 03 сарын 28-ны өдөр [tosontsengel\\_tg@shuukh.mn](mailto:tosontsengel_tg@shuukh.mn) цахим хаягаар алдээг дүүж ажилын бичиг тус шүүхийн байрны 204 тоотод хүлээн авна

99858526  
Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын газар



2.5.3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020.09.01-ний өдрийн 102 дугаар тушаалаар баталсан “Шүүх хуралдааны явцыг мэдээлэх, цахим систем ашиглах журам”-ын 1.6.2, 3.1.4-т заасны дагуу Иргэний хэргийн **154**, Эрүү, зөрчлийн хэргийн **620**, Цагдан хорих **18**, Хянан магадлангийн **5** нийт **797** товыг тухай бүр цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан ажилласан.



### Нарийвчилсан журам

Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл гомдол, санал, хүсэлт, дүгнэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн даргалагчийг сугалаагаар томилох нарийвчилсан журам батлах тухай

өдрийн 141/ЗТ2025/00049 дугаартай “Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол”-ыг цахим хуудаст байршуулан ажилласан байна.

2.5.5. Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх дэх Эвлэрүүлэн зуучлалын цахим хаягаар нийт 72 мэдээ мэдээлэл олон нийтэд нийтэлж хуваалцсан байна. Мэдээллийн самбарт нийт шүүх хуралдааны тов болон иргэдэд өгөх эрх зүйн мэдээллийг байршуулж, шүүх дэх Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар пэйж хуудас нээж, тойргийн сумдын иргэдийн facebook группт шторк, болон шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг тогтмол мэдээлж байна.



Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх дэх Эвлэрүүлэн...

97 likes · 155 followers

Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх дэх Эвлэрүүлэн зуучлал  
29 Aug · 🌐

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын газар  
Otgon Jargal · 29 Aug · 🌐

ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ТУСААХ НАРЫН УТАС, E-МАИЛ ХАЯГИЙН ЖАГСААЛ

№	Шүүгчийн нэр	Шүүгчийн туслах	Өрөөний дугаар	Шүүгчийн туслахын утасны дугаар	Мэйл хаяг
1	Ерөнхий шүүгч Б.Уртнасан	Б.Батбаяр	202	70468177, 99801907	otkhan.770@shuukh.mn
2	Шүүгч Б.Өлзийшишээ	Т.Буржинлхам	206	70468177, 98333594	otkhan.768@shuukh.mn
3	Шүүгч П.Доржбал	Б.Энхриймаа	205	70468178, 94420895	otkhan.768@shuukh.mn


АВАЛАХ УТАС: ШҮҮХИЙН МЭДЭЭЛЭЛЭЙ АВААГААР: 70444081 ШҮҮХ ДЭХ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛ: 70444075

Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх дэх Эвлэрүүлэн зуучлал  
6 Oct · 🌐

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын газар  
Otgon Jargal · 6 Oct · 🌐

СУМДАД НҮҮДЭЛЛЭН АЖИЛЛАЛАА  
Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн Мэдээлэл лавлага...





2025 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 4 иргэдийн төлөөлөгч эрүү, иргэн шүүх хуралдаанд оролцсон байна. Уг иргэдийн төлөөлөгчийн оролцооны мэдээллийг шүүхийн цахим хуудаст байршуулж ажилласан.

2.5.6. Шүүхэд гаргах нэхэмжлэлийн загвар, бүрдүүлбэр, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн холбогдох заалт, торгууль, хураамж төлөх банкны дансны дугаар зэрэг мэдээллийг цахим хуудас, байршуулж шинэчлэл өөрчлөлтийг тухай бүр хийж байна.

Утас: 70468075 Цахим шуудангийн хаяг: tosontsengel\_tg@shuukh.mn Санал, хүсэлт

**ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХ**  
TOSONTSENDEL SOUM OF ZAVKHAAN PROVINCE IN INTER COURT

ШҮҮХ ТАМГЫН ГАЗАР МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ИРГЭН ТАНД

**Загварын нэр**

- Зээлийн гэрээний нэхэмжлэл
- Ажилд эргүүлэн тогтоолгох
- Эвлэрүүлэн зуучлалд өргөдөл гаргах
- Гэрлэлт цуцлуулж, хүүхдийн асрамж, тэтгэлэг гаргуулах хүсэлт
- Гэрээний үүрэг
- Хамтын амьдралтай байсныг тогтоолгох

ШҮҮХ ТАМГЫН ГАЗАР МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ИРГЭН ТАНД ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛ

Бусад мэдээ, мэдээлэл

**Шүүхийн улсын тэмдэгтийн хураамж тооцоолох**

Эрх зүйн маргааныг хянан шийдвэрлүүлэхээр өргөдөл, гомдол, нэхэмжлэл шүүхэд гаргах болон шүүхээс баримт бичиг олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.

Тооцоолох

Утас: 70468075 Цахим шуудангийн хаяг: tosontsengel\_tg@shuukh.mn Санал, хүсэлт Сайн дураар Хуучин цахим хуудас

**ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХ**  
TOSONTSENDEL SOUM OF ZAVKHAAN PROVINCE IN INTER COURT

ШҮҮХ ТАМГЫН ГАЗАР МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ИРГЭН ТАНД ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛ АРХИВЫН ҮЙЧИЛГЭЭ ШИЛЭН ДАНС

Архивын лавлагаа хуулбар олгох

ШҮҮХИЙН АРХИВААС ХУУЛБАР ЛАВЛАГАА АВАХАД ШААРДАГДАХ МАТЕРИАЛ

1. Хувь хүн шүүхийн архивт хадгалагдаж байгаа хэрх, материалаас хуулбарлан авахдаа өөрийн ирсэний үнэмлэх, байгуул бол түүнтэй адил түвшний бичиг баримт/хэрх материалаас хуульчлах авах талаарх хүсэлтийг газраар бичиг ирүүлэх. Мөн /100900005001/ тосг Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны дансанд архиваас авах буй хуулбарыгхаа тоогоор /сг нүүр 500 төгрөг/ төлбөр төлсөн байх.

**ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХ**  
TOSONTSENDEL SOUM OF ZAVKHAAN PROVINCE IN INTER COURT

Мэдээ, мэдээлэл

**Тусгайлан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа маягт**

2024-10-22 • Үзсэн: 178



2.5.7. Тус шүүхийн тамгын газрын **2016-2024** оны үйл ажиллагааны тайланг өөрийн шүүхийн цахим хуудаст байршуулж, иргэд олон нийтийг шүүхийн үйл ажиллагаатай ил тод нээлттэй танилцах боломжийг бүрдүүлэн ажиллалаа.


Завхан аймгийн тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх  
TOSONTSENCEL SUM OF ZAVKHAN PROVINCE IN INTER COURT

ШҮҮХ - ТАМГЫН ГАЗАР - МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ИРГЭН ТАНД

2024 оны үйл ажиллагааны

2024 оны үйл ажиллагааны тайлан  
ТАМГЫН ГАЗРЫН ТАЙЛАН · 2025-05-26

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНД ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТИЙН



2.5.8. Хуульд тусгайлан зааснаас бусад нээлттэй шүүх хуралдааны үйл ажиллагааг үзэж сонирхох боломжийг олгож тухайн шүүхэд явагдаж буй нээлттэй хуралдааныг шүүхийн үүдний дэлгэцээр дамжуулан гаргадаг бөгөөд иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийн ажилтныг шүүх хуралдааны дэгд заасны дагуу оролцуулах боломжоор ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд нээлттэй шүүх хуралдаанд ажиглагчаар **26** иргэн биечлэн оролцсон байна.

2.5.9. 2025 онд тус шүүхээр хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн талаарх төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулж **38** шийдвэр, процессын тоймыг шүүхийн цахим сайт болон фейж хуудсаар мэдээлэл түгээж ажиллалаа.

Завхан аймгийн тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх  
TOSONTSENCEL SUM OF ZAVKHAN PROVINCE IN INTER COURT

ШҮҮХ - ТАМГЫН ГАЗАР - МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ИРГЭН ТАНД - ЗВЛЭРҮҮЛЭН ЗҮҮЧЛЭЛ - АРХИВЫН ҮЙЛЧИЛГЭЭ - ШИЛЭН ДАНС

Шийдвэрийн тойм

Төрийн тусгай алба хаагч хөнгөн гэмт хэрэг үйлдсэн нь ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй

Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан үедээ согтууруулах ундаа хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэв


ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ САНАЛТАЙ ИРҮҮЛСЭН ХЭРГИЙГ ПРОКУРОРТ БУЦААВ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдал нотлогдоогүй үндэслэлээр хэргийг буцаав

2.5.10. ШЕЗ-ийн 2024.12.04-ний өдрийн 276 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй шүүх хуралдааны бичлэгийг шүүхийн цахим хуудаст байршуулах журам”-д нийцүүлэн төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад шүүх хуралдааныг шууд дамжуулалтаар нэвтрүүлэх ажлыг холбогдох журамд заасны дагуу зохион байгууллаа.



2.5.11. Тус шүүхийн тамгын газраас 2025 онд ШМТҮАНЖ-ын 8.8.1-т заасны дагуу шүүхийн үйл ажиллагааны талаар 2025.05.28, 2025.10.07-ны өдөр тус тус 2 удаа олон нийтээс санал, асуулга авах ажлыг зохион байгуулж, дүн шинжилгээ хийн, ойлгомжтой байдлаар мэдээлэл бэлтгэн тус шүүхийн цахим хуудас болон сайтад байршуулан ажилласан байна.



2.5.12. Ерөнхий зөвлөлөөс гарсан шийдвэр тогтоолыг мэдээллийн сан өөрсдийн дотоод сүлжээнд үүсгэж тухай бүр шүүгч, ажилтнуудад танилцуулах арга хэмжээ авч, шүүхийн захиргааны ажилтнууд мэдээлэл авсан талаар гарын үсэг зурж баталгаажуулдаг бөгөөд тухайн шүүхийн шүүн таслах болон бусад ажиллагааны талаарх мэдээллийн шүүхийн цахим хаяг болон фейж хуудсанд байршуулж, тойргийн сумдын тамгын газрын байранд байрлах мэдээллийн самбар, ажиллах тохиолдолд иргэд олон нийтэд тухай бүр мэдээлэл өгч ажилласан байна.

2.5.13. 2025 онд тус шүүхийн шүүн таслах ажиллагааны сар, улирал, хагас, бүтэн жилийн мэдээг цаг тухайд нь гаргаж, ШЕЗ-д хүргүүлэн олон нийтэд ойлгомжтой байдлаар бэлтгэн цахим хуудсанд тогтмол байршуулж байна. Мөн шүүхийн шийдвэрийн сангийн мэдээг сар бүрийн 30-ны өдөр ШЕЗ-д хүргүүлэн ажиллаж байна.





## ДҮН ШИНЖИЛГЭЭ

Тайлант хугацаанд тус шүүхийн тамгын газарт “Олон нийттэй харилцах” баг байгуулагдаж ажилласан байна. Уг баг нь иргэд олон нийтэд чиглэсэн, шүүхийн үйл ажиллагааны талаарх цаг үеийн мэдээ мэдээлэл, шүүн таслах ажиллагааны сар, улирал бүрийн мэдээг иргэд олон нийтэд ойлгомжтой байдлаар бэлтгэн сайт, пэйж хуудсанд байршуулж, түгээн ажиллаж хэвшсэн нь дэвшилттэй үйл ажиллагаа гэж үзлээ.

Мөн тус шүүхийн тамгын газар нь тойргийн сумдад “Нээлттэй шүүх өдөрлөг” зохион байгуулж, иргэд олон нийтэд шүүн таслах ажиллагаа, шүүхийн тамгын газрын үйл ажиллагаа, шүүхийн иргэдийн төлөөлөгч, эвлэрүүлэн зуучлалын талаар тодорхой мэдээлэл өгч ажилласан нь иргэдийн сонирхлыг татсан шүүхийн үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд олон нийтэд мэдээлэл өгсөн нь ач холбогдолтой арга хэмжээ болж чадсан байна.

### ГУРАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, АЖИЛ САЙЖРУУЛАХ САНАЛ

#### 3.1. Нэгдсэн дүгнэлт

Тус шүүхийн тамгын газраас шүүгч, шүүхийн захиргааны ажилтан албан хаагчдын гаргасан санал санаачилагыг дэмжиж, шүүхийн шүүн таслах ажиллагааг хэвийн тогтвортой, тасралтгүй явуулах, хэргийн хөдөлгөөнд гарч буй алдаа зөрчлийг арилгах, дахин давтан гаргуулахгүй байх, шүүгч, ажилтнуудын ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, шүүхийн байранд их засварын ажлыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан гүйцэтгэж, шүүхийн үйл ажиллагаа, ололт амжилтыг иргэд, олон нийтэд сурталчлах, шүүхээр үйлчлүүлж буй иргэдэд чанартай, мэдрэмжтэй үйлчилгээг ил тод, түргэн шуурхай үзүүлэх зэрэг олон арга хэмжээг амжилттай биелүүлж ажиллалаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хэргийн хөдөлгөөний удирдлагын цахим хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр тус шүүх нь 2025 оны 1 дүгээр улиралд 99.75%, 2 дугаар улиралд 100%, 3 дугаар улиралд 96,25% үнэлэгдэж, “Бүрэн хангалттай” гэсэн үнэлгээ авсан байна. Дээрх үнэлгээний үр дүнгээс үзвэл шүүхийн захиргааны ажилтнуудыг мэргэжлийн арга зүйгээр тогтмол ханган ажилласан нь үр дүнд хүргэсэн болох нь харагдаж байна.

Тамгын газрын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны чиглэлээр тус шүүхийн албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр эрхлэн явуулж байна. Архивт хадгалагдаж байгаа баримтуудаас хадгалах хугацаа дууссан, эрх зүй, түүх, эрдэм шинжилгээний болон практикт ач холбогдолгүй болсон 2005 оны 175, 2018 оны 366, 2019 оны 245, 2020 оны 290 түр хадгалах иргэний хэрэг, эвлэрүүлэн зуучлалын 2014-2019 оны 629 оны устгах материалуудын жагсаалтыг үйлдэж Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архивын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комисст тус шүүхийн тамгын газрын 2025.10.22-ны өдөр, Улсын ерөнхий прокурорын газрын Эрүүгийн тусгай архивд 2017-2023 оны байнга хадгалах 34 хадгаламжийн нэгж буюу 13 эрүүгийн хэрэг, Завхан аймгийн Прокурорын газарт түр хадгалах 2017-2023 оны түр хадгалах эрүүгийн хэрэг 112, 2017-2023 оны зөрчлийн



хэрэг 354, 2024 оны шийтгэх тогтоолын өнгөн хувь 4, 2024 оны зөрчлийн эрх зүйн актын баримтууд 27, нийт 497 хадгаламж нэгжийг хүлээгэн өгөх ажлыг тус тус зохион байгуулсан байна. Мөн архивын баримтын цахимжуулалт сайн хийгдсэн, архивын баримвуудыг хугацаандаа шилжүүлсэн нь шүүхийн мэдээллийн хүртээмж, хурд, архивын хяналтыг сайжруулсан байна. 2025 оны 09 дүгээр сард Завхан аймгийн Улсын үзлэгийн дэд комиссоос зохион байгуулсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам" болон "Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль" болон бусад хууль журамд нийцүүлэн Архив, албан хэрэг хөтлөлтийн урьдчилсан үзлэгт шалгуулан 97%-тай үнэлэгдэн шүүхийн архивын зүйн үйл ажиллагааг үнэлгээний өндөр үзүүлэлттэй гэж дүгнэж болно.

Иргэдийн шүүхэд мэдүүлэх эрхийг хангах зорилгоор тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шүүхийн цахим хуудсыг шинэчилж, иргэдийн эрх зүйн боловсролд зориулсан мэдээллүүдийг тогтмол оруулж хэвшсэн байна.

Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор 2025 онд тус шүүхийн 3 шүүгчид хуулиар зөвшөөрсөн бие хамгаалах хэрэгсэл болох "Цахилгаан бороохой"-г шинээр олгосон бөгөөд тухайн бие хамгаалах тусгай хэрэгслийн хадгалалт, хамгаалалтад тухай бүр хяналт тавин ажиллаж байна.

Тус шүүхийн шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг тусгаарлах өрөөнд саатуулагдсан иргэний аюулгүй байдлыг хангах үүднээс хана болон хамгаалалтын төмөр хаалтанд зөөлөвч суурилуулж, хяналтын камер байршуулан нэмэлт гэрэлтүүлэг хийж өрөөг бүрэн засварласан байна. Мөн аюулгүй байдлыг хангах үүднээс шүүхийн байрны нийт өрөөний хаалганы лацийг шинэчилж, өрөөнүүдийн нөөц түлхүүр хадгалах хайрцаг байршууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн иргэнд үзүүлэх шүүхийн үйлчилгээ үр нөлөө, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сул хараатай болон харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан брайль үсгээр гарын авлага бэлтгэн гаргалаа.

Шүүхийн байр руу нэвтрэх хашааны үндсэн хаалгыг шинэчилж, налуу зам бүхий гүйдэг хаалга болгон сольж суурилуулсан. Энэхүү шинэчлэл нь иргэд, үйлчлүүлэгчдийн шүүхийн байранд саадгүй, хялбар нэвтрэх боломжийг бүрдүүлж байна.

Мөн шүүхийн иргэдэд үйлчлэх хэсгийн 1 давхарын хана мөөгөнцөртөж эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон учир чийгнээс хамгаалах хавтангаар сольсон. Шүүн таслах ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, албан тасалгааг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх ажлын хүрээнд аюулгүй ажиллагааг хангах, халаалтын тогтвортой байдлыг сайжруулах зорилгоор шүүхийн байрны уурын зуухны хуучин яндан нь ашиглалтын хугацаа дууссан, зэврэлт үүссэн, утаа алдах зэрэг асуудалтай болсон тул шинэчилсэн байна.

Шүүхийн захиргааны ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор тус шүүхийн захиргааны ажилтнуудыг сахар, элэгний В, С вирусийн шинжилгээ болон биеийн индексийн үзлэгт хамруулсан,



уурын зуухны галч нарын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орчинг сайжруулах зорилгоор галч нарын ажлын байрлах ахуйн байрыг тохижуулан засварласан, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс олгосон иж бүрэн тавилгуудыг 17 шүүхийн захиргааны ажилтнуудад хуваарилсан, эрүү, иргэний хэргийн шүүх хуралдааны залны ханыг будаж шинэлчилсэн, шүүхийн захиргааны ажилтнуудыг спортын тэмцээн уралдаанд идэвхтэй хамруулсан зэрэг ажлуудыг хийж хэрэгжүүллээ.

Тус шүүхийн тамгын газрын дэргэдэх ёс зүйн дэд хороо нь 4 сургалтыг шүүхийн захиргааны ажилтнуудад сургалтыг зохион байгуулсан. 2025 онд тус шүүхийн тамгын газрын шүүхийн захиргааны ажилтнууд нь ёс зүй, сахилга хариуцлага алдалгүй, ёс зүйн зөрчил гаргахгүй ажилласан нь өмнө онтой харьцуулахад шүүхийн захиргааны ажилтнуудын ёс зүйн харилцаа хандлагад ахиц гарсан гэж үзэж байна.

### 3.2. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил сайжруулах санал

Завхан аймгийн Тосонцэнгэл сум нь Монгол улсын хамгийн хүйтэн газруудын нэг бөгөөд цаг агаарын эрс тэс, хүйтэн нөхцөлд үйл ажиллагаа явуулдаг өвөлдөө -45-аас -52 хэм хүртэл хүйтэрдэг. 2021 онд ШЕЗ-өөс олгосон “Renualt duster” автомашин нь тус суманд өвлийн улиралд ашиглахад тохиромжгүй, хэт хүйтэнд асдаггүй, “Prado-150” 2013 онд тус шүүхийн шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхээр үйлчилгээнд явж эхэлсэн, ашиглалтын хугацаа дууссан, тойргийн сумдад шүүхийн үйлчилгээг хүргэх, мөн шүүгч шүүх бүрэлдэхүүнд ажиллахад хүндрэлтэй байгаа тул албаны автомашины парк шинэчлэлт хийх шаардлагатай байна.

Шүүхийн үйлчилгээг иргэд олон нийтэд хялбар байдлаар хүргэх зорилгоор цахим системийг орчин үеийн дэвшилтэт технологид нийцүүлэн системийн хөгжүүлэлтэд анхаарч, сайжруулах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай гэж үзлээ.

Цаашид энэхүү хүрсэн амжилтаа улам бүр бататгаж, алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дахин давтан гаргахгүй байх, 2026 онд шүүхийн үйлчилгээг иргэд олон нийтэд цахим хэлбэрээр хүргэх зорилго, зорилтыг дэвшүүллээ.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ЭНХЦЭЦЭГ